Мөнгө угаахтай тэмцэх бүтэц, түүний үр нөлөөг тойрсон мэтгэлцээн нь мөнгө угаахтай тэмцэх эрхзүйн орчин хурдацтай өөрчлөгдөхөд хүргэж байна. Тухайлбал, зохицуулалтын цоорхойг арилгахын тулд Европын холбооны Мөнгө угаахтай тэмцэх тав дахь удирдамжид гишүүн орнуудын санхүүгийн мэдээллийн албадын мэдээлэл солилцохтой холбоотой асуудалд өөрчлөлт оруулахаар санал гаргасан байна. (Bozhilova, 2018)

Дээрх судалгааны ажлуудаас үзэхэд олон улсын хэмжээнд мөнгө угаахтай тэмцэх эрхзүйн баримт бичиг мөрдөгдөж, институт ажиллан мөнгө угаахтай тэмцэх бүтэц бүрэлдэн тогтсон байна. Улс орон бүрийн хууль эрхзүй, засаг захиргаа, нийгэм, эдийн засаг, санхүүгийн бүтцийн ялгаатай байдлаас шалтгаалан ФАТФ-аас гаргасан зөвлөмжүүд улс бүхэнд үр дүнтэй байж чадахгүй байгаа ч мөнгө угаах гэмт хэргийг таслан зогсоход дорвитой нөлөө үзүүлдэг байна. Гэмт хэрэгтэнд оногдуулсан ялын хэмжээнээс илүүтэйгээр хураан авч, улсын орлого болгосон хөрөнгийн хэмжээгээр олон улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүнтэй байдлыг үнэлдэг байна. Манай улсын хувьд НҮБ-аас гаргасан конвенцод нэгдэн орсон, ФАТФ-н гишүүн орон болж мөнгө угаахтай тэмцэх бүтцийг үүсгэсэн байна.

Мөнгө угаах үйлдлийн бусад салбар болон эдийн засагт үзүүлэх нөлөө.

Судлаачид Мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог шүүмжлэхээс гадна мөнгө угаах гэмт хэргийн бусад салбар болон эдийн засагт үзүүлэх нөлөөнд анхаарлаа хандуулсан байдаг.

Schwarz (2011) нэр бүхий 33 ширхэг офшор бүсүүд бохир мөнгө татах, мөнгө угаах зорилгоор ямар бодлого хэрэгжүүлж, хөнгөлөлт үзүүлдэг талаар судалсан. Тэрээр офшор бүсүүд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн

хууль, журам баталж, мөрдөх тийм ч дуртай бус, олон улсын зүгээс дарамт шахалт үзүүлсэн тохиолдолд мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа мэтээр дүр эсгэдэг гэж үзсэн байна. Түүнчлэн (Slemrod & Wilson, 2009) нарын офшор бүсүүд нь хөрш улсуудын татварын бааз суурийг өөртөө шилжүүлэн авах замаар тэдгээр улсуудыг “шимэгчилж” амьдардаг, (Dharmapala, 2008) татварын таатай нөхцөл үзүүлэх замаар аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудтай татварын хувь хэмжээгээр өрсөлддөг гэсэн үзэл баримтлалуудыг дурдсан байна. Picard, Pieretti (2011) нар хар жагсаалтад оруулах гэх мэт улс төрийн дарамт шахалт офшор бүсэд хэрхэн нөлөөлж болох талаар, офшор бүсүүдийн мөнгө угаахтай тэмцэх дүрэм журмыг хэрэгжүүлэх чадварын талаар судалсан. Хэрвээ үзүүлэх дарамт шахалт хөрөнгө оруулагчийн нэр төрд сөргөөр нөлөөлбөл офшор бүст харьяалагдах банкнууд мөнгө угаахтай тэмцэх дүрэм журмыг мөрдөх боломжтой гэж үзсэн.

Mitchell (1998) хууль бусаар олсон их хэмжээний хөрөнгийг нягтлан бодогч болон бусад мэргэжилтнүүдийн тусламжгүйгээр угаах боломжгүй гэж үзээд нягтлан бодогчдын хууль бус үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгаа талаар судалгаа хийсэн. Ravenda (2017) Италийн гэмт бүлгийн бохир мөнгийг угаахад ашигласан нягтлан бодох бүртгэлийн аргын талаар судалсан. Харин Botes, Saadeh (2018) нар ийм төрлийн хууль бус үйлдэлтэй тэмцэхийн тулд эдийн засгийн шинжилгээ хийх шаардлагатай гэж нэмэлтээр дүгнэсэн.

Dowers, Palmreuther (2003), Drayton (2002) нар мөнгө угаалт нь санхүүгийн болон нийгэм эдийн засгийн тогтворгүй байдлыг үүсгэж, авлига хээл хахуулийг өөгшүүлэх замаар эдийн засагт сөргөөр нөлөөлдөг гэж үзсэн байна. Hendriyetty, Grewal (2017) нар мөнгө угаалт нь гэмт хэргийн гаралт болон далд эдийн засгийн хэмжээг ихэсгэж, төсөвт орж ирэх татварын хэмжээг бууруулдаг гэж дүгнэсэн.

П.В.Ревенков, А.Г.Воронин (2012) нар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдэл нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал болон олон улсын тогтвортой байдалд аюул занал үзүүлдэг гэж баталсан байна. Тэд энэхүү аюул занал нь шууд байдлаар татварын орлогыг бууруулахын зэрэгцээ үндэсний мөнгөн тэмдэгтийн үнэ болон хүүгийн түвшинд сөргөөр нөлөөлж улсын нэр хүндэд үлэмж хэмжээгээр хохирол учруулдаг гэж үзсэн байна.

Энэ чиглэлээр бичигдсэн судалгааны ажлуудаас дүгнэж үзвэл мөнгө угаах гэмт хэрэг нь тухайн улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн салбарт сөрөг нөлөө үзүүлж, далд эдийн засгийг нэмэгдүүлж, авлигын үндэс суурь болдог байна. Мөнгө угаахад нягтлан бодогч гэх мэт мэргэжлийн хүмүүсийн оролцдог бөгөөд тус гэмт хэргийг илрүүлэхийн тулд санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ, мөрдлөг хийх шаардлага үүсдэг байна. ФАТФ-н зөвлөмж 30-д заасны дагуу

манай улсын хууль сахиулах байгууллагууд санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй мөрдөгчид ажиллуулаж мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэж байна.

Мөнгө угаах үйлдлийн цар хүрээ.

Мөнгө угаах үйлдлийн цар хүрээг тодорхойлсноор түүний хэр ноцтой болон макро эдийн засагт үзүүлэх нөлөөг үнэлэх боломжтой болно. Walker (1999) угаагдсан мөнгөний хэмжээг тооцоолохын тулд “Walker model of global money laundering” загвар боловсруулсан. Уг загварыг ашиглан өргөн хүрээний нээлттэй мэдээллийн сан дээр үндэслэн Европ болон Хойд Америкт 1999 онд жилд 2.85 тэрбум доллар угаагддаг гэж тооцоолсон.

Unger (2013) угаасан мөнгөний хэмжээг 2 аргаар тодорхойлж болно гэж үзсэн. Үүнд дотоодын нийт бүтээгдэхүүн, гэмт хэргийн замаар олсон хөрөнгийн хэмжээ, төлбөрийн балансын зөрүү гэх мэт үзүүлэлт ашиглан, эсвэл “Walker-Gravity model” гэх мэт эдийн засгийн загвар ашиглан угаагдсан мөнгөний хэмжээг олж болно гэж бичсэн байна. Нөгөө талаас дээрх үнэлгээ нь төөрөгдөлд оруулсан, тодорхой бус гэж Thoumi (2005) зэрэг эрдэмтэд шүүмжилсэн байдаг.

Дэлхий даяар жил бүр угаагдаж буй мөнгөний хэмжээг тодорхойлох чиглэлд судлаачид төрөл бүрийн шинжилгээ хийсэн байна. Шинжилгээний үр дүнгээс харахад их хэмжээний мөнгө угаагдаж байгаа нь тус гэмт хэрэгтэй дорвитой тэмцэх шаардлагатайг харуулж байна.

Мөнгө угаах шинэ боломжууд.

Barone, Schneider (2018) нар кибер угаалт болон электрон автомат төхөөрөмж ашиглан мөнгө угаах аюул занал ихсэж байна гэж дүгнэсэн байна. Dostov, Shust (2014) нар Digicash, Биткойн гэсэн криптовалютыг тэдгээрийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аюул занал талаас нь судлаад аюул занал багатай гэж үзсэн. Учир нь криптовалот тодорхой хүрээнд эргэлддэг, ашиглахад тусгайлан сургалт шаардлагатай зэрэг хүндрэл үүсгэдэг. Түүнчлэн криптовалютыг фиат мөнгөнд хувиргах шаардлага гардаг, тэгш бус хуваарилагддаг, ханшийн өндөр хэлбэлзэлтэй учир хүмүүсийн анхаарлыг татахгүй бөгөөд зохицуулах баримт бичиг гаргахын тулд криптовалот тус бүрийг шинж чанараар нь судлах хэрэгтэй гэж дүгнэсэн.

Криптовалот ашиглан мөнгө угаах аюул заналыг бууруулахын тулд зохицуулсан баримт бичиг гаргах шаардлагатай гэсэн саналыг Choo (2015) дэмжсэн байдаг.

Криптовалютын эзэн холбогдогчгүй, гүйлгээг нь мөшгөх боломжгүй байдлыг шийдэхийн тулд Turner, Irwin (2018) нар төрөл бүрийн программын тусламжтайгаар гүйлгээний эзэн холбогдогчийг тогтоохыг оролдсон. “Wireshark”, “blockchain.info” зэрэг программын тусламжтайгаар блок гинжин хэлхээгээр дамжуулан гүйлгээг ямар хаягт хүрч байгааг мөшгөх боломжтой байсан бол тухайн гүйлгээ хүлээн авсан хаягийн эзэн холбогдогчийг тогтоох боломжгүй байсан байна. Туршилтаар 0.00449934 ширхэг биткойны гүйлгээг ямар хаягт хүрч байгааг тогтоосон байна.

Технологи хөгжихийн хэрээр криптовалют болон бусад шинэ технологийг ашиглан мөнгө угаах эрсдэл нэмэгдсэн байна. Иймээс криптовалюттай холбоотой харилцааг зохицуулсан эрхзүйн баримт бичиг шаардлагатай гэсэн дүгнэлтэд дээрх эрдэмтэд хүрсэн байна.

Манай улсын хувьд “Виртуал хөрөнгийн тухай” хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа нь сайшаалтай зүйл юм. Криптовалют ашиглан мөнгө угаах чиглэлд мэргэжлийн эрдэмтэн, судлаач, шинжээчид эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийснээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн нэмэгдэнэ гэж үзэж байна.


Мөнгө угаах үйлдлийг илрүүлэх.

Гэмт үйлдэл ихэссэнтэй холбоотойгоор хууль бус үйлдлийг автоматаар илрүүлэх төрөл бүрийн систем бүтээх ажлууд хийгдсэн байна. Ngai (2011) даатгалын залиланг илрүүлэх чиглэлээр өгөгдлийн шинжилгээний аргыг хэрэглэх нь ихэссэн боловч мөнгө угаах гэмт хэрэг, ипотек, үнэт цаасны залиланг илрүүлэх чиглэлд дутагдалтай байна гэж үзсэн.

Zhang (2003) корреляци шинжилгээнд тулгуурласан холбоос судлах арга /Link Discovery based on Correlation Analysis- LDCA/ ашиглан мөнгө угаах гэмт хэрэг мөрдөх явцад цугларсан нотлох баримт, мэдээ, мэдээлэлд шинжилгээ хийж ижил төстэй шинж чанараар нь гэмт бүлэглэлийн гишүүдийг тогтоож болох юм гэсэн санаа дэвшүүлсэн. Ингээд бодитоор үйлдэгдсэн мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажлын хүрээнд авагдсан нотлох баримтаас овог нэр, ажлын газрын нэр, гүйлгээ хийсэн огноо, цаг, хаяг, гүйлгээний дүн зэрэг мэдээллийг сонгон авч боловсруулсан. LDCA аргын тусламжтайгаар 332 бичиг баримт, 252 хувь хүний мэдээлэлд шинжилгээ хийж, 7 хувь хүнийг гэмт бүлгийн гишүүд гэж тодорхойлсон нь бодит байдалтай нийцсэн үр дүн үзүүлсэн.

Корреляци шинжилгээнд тулгуурласан холбоос судлах арга /Link Discovery based on Correlation Analysis- LDCA/ нь корреляцийн хэмжүүрийг ашиглаж

хоёр өгөгдлийн элементүүдийн ижил төсөөтэй байдлыг тодорхойлох замаар өгөгдлийн хоорондын холбоог судалдаг байна.



Zdanowicz (2009) худалдааны салбарт хийгдэж байгаа мөнгө угаалтыг илрүүлэх чиглэлд судалгааны хийсэн. Тэрээр бараа таваар нийлүүлэгч улсын зах зээлийн үнэ болон дэлхийн зах зээлийн үнийг АНУ-ын экспорт импортын мэдээтэй харьцуулах замаар мөнгө угаалт хийхэд ашиглаж байж болзошгүй бараа таваар болон улсыг тодорхойлсон. Жишээлбэл нийлүүлэгч улсад зарагдаж байгаа кетчүпний үнэнээс 5 хувиар хямд эсвэл 95 хувиар өндөр үнээр худалдан авалт хийсэн гүйлгээнүүдийг мөнгө угаалт хийх эрсдэлтэй гэж үзсэн.

Unger (2013) үл хөдлөх хөрөнгийн салбарт Zdanowicz (2009)-н дээд дурдсан загварыг ашигласан бол Bidabad (2017) аж ахуйн нэгжийн арилжааны банкаар хийсэн гүйлгээг Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлантай нь харьцуулах замаар мөнгө угаалтыг илрүүлж болох юм гэж үзсэн.

Floris (2020) мөнгө угаалтыг илрүүлэх дараах аргын тухай дурдсан. Дүрэмд суурилсан аргын үед урьдчилан тодорхойлсон дүрмүүдийн үндсэн дээр гүйлгээг шинжилнэ. Жишээлбэл Б улсаас шилжин орж ирж буй 7500 еврогоос дээш дүнтэй бүх гүйлгээг анхаарах шаардлагатай гэж тэмдэглэнэ. Уг тэмдэглэгдсэн гүйлгээг шинжлэх пирамид хэлбэрийн бүтэц бүхий төрөл бүрийн түвшний шинжээчид банк санхүүгийн байгууллагад ажиллана. Анхан шатны шинжээч тэмдэглэгдсэн гүйлгээг хуурамч дохио гэж үзэх эсвэл шинжилгээ хийх шаардлагатай гэж үзэн дараагийн шатны шинжээчид шилжүүлнэ. Эцэст нь хамгийн өндөр түвшний шинжээч Санхүүгийн мэдээллийн албанд уг гүйлгээг мэдээлэх эсэхийг шийднэ. Уг аргын сул тал нь их хэмжээний хуурамч дохио илэрдэг, босго дүн үр дүнтэй байдаггүй, өгөгдлийн боловсруулалт үр дүнтэй байдаггүй болон мөнгө угаалтыг автоматаар танин мэдэх боломжгүй байдал юм. Дүрэмд суурилсан аргаар гүйлгээнд үр дүнтэй шинжилгээ хийхийн тулд тусгай арга хэрэгслүүдийг бүтээсэн байдаг. Тухайлбал хиймэл оюун ухаанд суурилсан Financial Crimes Enforcement Network AI Systems (FAIS) гэх хэрэгсэл нь 336 дүрэм ашиглан гүйлгээг шинжилж ангилдаг байна. Тус

хэрэгсэл нь гүйлгээг ангилах хурдыг нэмэгдүүлдэг хэдий ч гүйлгээг цаашид мөрдөн шалгах, шинжилгээ хийхэд хүний нөөц шаардлагатай хэвээр байна. Анхаарах шаардлагатай гэж үзсэн гүйлгээ бүрийг шинжлэх нь зардал өндөртэй бөгөөд үр дүн багатай юм. Түүнээс гадна зөвхөн тодорхойлсон дүрмийн дагуу гарч ирсэн гүйлгээг шинжлэх бөгөөд технологи хөгжихийн хэрээр мөнгө угаах шинэ схем үүсэж байгаа өнөө үед үр дүн муутай юм.

Мөнгө угаалт хийсэн гүйлгээг тогтмол шинжлэн мөнгө угаалтын шинэ схем илэрсэн тохиолдолд мөнгө угаалтын схемийн жагсаалтад нэмэх замаар мөнгө угаах схемийг баяжуулж байх нь үр дүнтэй юм.

Сэжигтэй гүйлгээг тодорхойлох, хяналт хийх ажлын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд сайжруулсан эсвэл шинэ арга хэрэгтэй.

Rule-Based Bayesian Network буюу Дүрэмд суурилсан Байес-н сүлжээ гэх аргыг Пакистаны улсын банкнаас гаргасан журамд үндэслэн Khan, Larik, Rajput, Haider /2013/ нар санал болгосон. Уг арга нь эхлээд хэрэглэгчийн зан төлөвт оноо олгох бөгөөд дараа нь хэрэглэгчийн зан төлөвийн түүхэн хандлагад үндэслэн оноог тооцон зөрүүг гаргадаг. Хэрэглэгчийн зан төлөвийн хэвийн хэмжээнээс их хэмжээний өөрчлөлт үзүүлсэн байвал гүйлгээг сэжигтэй хэмээн тэмдэглэнэ.

Clustering гэх арга нь компьютерын систем /machine learning technique/ гүйлгээнүүдийг ижил төстэй байдлаар нь ангилаад дараагаар нь ангилсан гүйлгээнүүд дундаас хэвийн бус гүйлгээг ялгаж авах арга юм. Энэ нь компьютер өөрөө ангилж ялгах учраас гүйлгээг тэмдэглэх эсвэл дүрэм зохиох шаардлагагүйгээрээ давуу талтай юм.

Social Network Analysis арга нь санхүүгийн гүйлгээ хийгдсэн данс хоорондын харилцаан дээр тулгуурласан, түүнийг шинжлэх арга юм. Энэ талаар Colladon & Remondi (2017) нар бичсэн байдаг. Тэрээр судалгаандаа хууль бус зүйл үйлдэхэд хэд хэдэн этгээдийн хооронд харилцах шаардлага гардаг гэж үзсэн бөгөөд гүйлгээнд оролцогч талуудын газар зүй, гүйлгээ, эдийн засгийн шинж чанараар нь үнэлж хоорондын харьцааг нь шинжилсэн.

Decision Tree арга нь machine learning technique ашиглан 1 үндэстэй, олон салаа мөчиртэй мод хэлбэрийн бүтцээр мэдээллийг ангилж ялгадаг. Liu, Qian, Mao, & Zhu (2011) нар Decision Tree арга ашиглан мөнгө угаах загварыг илрүүлэх аргыг санал болгосон.

Random Forests арга нь Decision Tree аргын өргөтгөсөн хувилбар бөгөөд Breiman (2001) хөгжүүлсэн байна. Тус аргыг хэрэглэх үед хэд хэд мод хэлбэрийн бүтэц үүсгэж мэдээллийг ангилдаг байна. Alvarez Jareno, Badal-Valero, & Pavia (2017) нарын Испани улсын бодит мөнгө угаах хэрэг дээр

хийсэн судалгаагаар энэхүү арга нь илүү үр дүнтэй байсан байна.

Хэрэглэгчийн хяналттай ангилах арга бол Support Vector Machines арга юм. Тус арга нь шугаман бус, төвөгтэй харилцааг боловсруулах чадалтай учраас мөнгө угаах эрсдэлтэй сэжигтэй гүйлгээг илрүүлэх ач тустай юм. Tang & Yin (2005) нар дүрэмд суурилсан аргыг орлож чадах арга гэж баталсан.

Neural Network арга нь хүний тархины хэлбэртэй төстэй бүтцээр ангилах арга юм. Тус арга нь төвөгтэй, шугаман бус харилцааг боловсруулах чадвартай. Lv, Ji, & Zhang (2008) нар энэхүү аргыг мөнгө угаахтай тэмцэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд ашиглавал хуурамч хариу гарах нь багасна гэж үзсэн.

Дүгнэж хэлэхэд, Machine learning techniques ашигласан Decision Tree, Random forests, Support vector machines, Neural Network гэх мэт аргууд нь дүрэмд суурилсан аргаас илүү үр дүн үзүүлж, өдөр бүр хийгдэж байгаа олон тооны гүйлгээнээс сэжигтэй гүйлгээг өндөр нарийвчлалтай ялган таних боломжийг олгох юм.

Монгол Улсын хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан мэдээлэх үүрэгтэй этгэдүүд, голчлон арилжааны банкнууд, тус хуулийн 5-р зүйлд заасны дагуу харилцагчийг танин мэдэх, тус хуулийн 7-р зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээлэл, 7.2 дах хэсэгт заасны дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогын талаарх мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлж байна. Санхүүгийн мэдээллийн албанаас сэжигтэй гүйлгээнд дүн шинжилгээ хийгээд шаардлагатай гэж үзвэл хууль сахиулах байгууллагад шилжүүлдэг байна. Хууль сахиулах байгууллагууд тусгай мэдлэг эзэмшсэн шинжээч-мөрдөгчдийн хийсэн эдийн засгийн шинжилгээнд тулгуурлан, мөрдөн шалгах ажлын ажлын арга хэрэгсэл, техник технологийг ашиглан сэжигтэй гүйлгээний мэдээллийг шалгадаг.

Тухайлбал Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 918 дугаартай шийтгэх тогтоолд дурдсанчлан Монгол Улсын хууль сахиулах байгууллага “Нигери улсын иргэн нь Монгол улсын нэр бүхий 3 иргэнтэй хамтран гадаад улсын компанитай ижил нэртэй компани Монгол Улсад үүсгэн байгуулж цахим хэрэгсэл ашиглан Турк улсын компанийг залиж 2.1 тэрбум төгрөгийн хохирол учруулсан, гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг ашиглан үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл худалдан авах, БНХАУ руу шилжүүлэх замаар мөнгө угаасан” гэх

хэргийг илрүүлэн шалгаж, прокурорын байгууллагад шилжүүлснийг Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2019 онд шийдвэрлэсэн байдаг. Шүүхээс дээрх иргэдэд 6-10 жилийн хорих ял эдлүүлэх, 17 ширхэг автомашин, 7 ширхэг уул уурхайн хүнд даацын тээврийн хэрэгсэл, 2 ширхэг орон сууц, 702.8 сая төгрөгийг хураан авч хохирол барагдуулахаар шийдвэрлэсэн байна.⁴

Арилжааны банкнуудаар өдөр тутам хийгддэг их хэмжээний гүйлгээнээс сэжигтэй гүйлгээг олж илрүүлэн мэдээлэх шаардлага үүсдэг. Өдөр тутам хийгдэж байгаа гүйлгээний тоо хэмжээнээс шалтгаалан сэжигтэй гүйлгээг илрүүлэхэд хүндрэл үүсдэгээс гадна арилжааны банкны ажилтны ур чадвар, хүнээс шалтгаалах хүчин зүйл зэргээс шалтгаалж сэжигтэй гүйлгээг илрүүлэхгүй байх эрсдэлтэй. Гүйлгээ нь дан ганц аж ахуйн нэгжид хамааралтай бус хувь хүн, иргэн гүйлгээ хийдэг нь сэжигтэй гүйлгээ илрүүлэх ажлыг улам хүндрүүлдэг. Гэсэн ч арилжааны банкнууд сэжигтэй гүйлгээнд хяналт тавих ёстой. Хяналт тавихтай холбоотойгоор арилжааны банкнууд комплаенсын зардлаа нэмэгдүүлэхэд хүрдэг бөгөөд хяналт нь үр дүнгүй бол тухайн банк төдийгүй улсын хэмжээний мөнгө угаахтай тэмцэх бүтцэд эрсдэл үүсдэг байна.

Харилцагчийн мөнгө угаахтай холбоотой гүйлгээ хийх эрсдэлийг үнэлсэн, өдөр бүр хийгдэж байгаа гүйлгээн дундаас сэжиг бүхий гүйлгээг ялган харуулах чадвар бүхий автомат систем ашиглах замаар дээрх ажлыг үр дүнтэйгээр, зардал багатайгаар зохион байгуулж болно гэж үзэж байна. Түүнчлэн компанийн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгагдсан мэдээллийг арилжааны банкаар дамжуулан хийгдсэн гүйлгээний мэдээлэлтэй харьцуулах замаар мөнгө угаах, татвараас зайлсхийх эрсдэлийг үнэлсэн загвар боловсруулан ашиглах боломжтой. Гадаад орны эрдэмтдийн энэ чиглэлд хийсэн судалгаа, шинжилгээний ажлыг судлах, өөрийн орны банк санхүү, нийгэм, эдийн засгийн орчинд нутагшуулах, цаашлаад Монгол Улсад тохирсон сэжигтэй гүйлгээг ялган таних автомат систем боловсруулах, бий болгох чиглэлд судалгаа хийх шаардлагатай.

Үүний үр дүнд аж ахуйн нэгжүүдэд мөнгө угаах эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл өндөр бүхий компанийн үйл ажиллагаанд нягт хяналт, мониторинг хийн, сэжигтэй гүйлгээг ялган таньж мэдсэнээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн нэмэгдэнэ гэж үзэж байна.

⁴ Шүүхийн шийдвэрийн цахим сан: https://shuukh.mn/single_case/39520?daterange=2019-01-01%20-%202019-12-12&id=1&court_cat=2&bb=1

Дүгнэлт

АНУ-д 1920-оод оноос гэмт хэргийн бүлэглэлүүд хууль бусаар олсон хөрөнгөө хууль ёсны мэт харагдуулж эхэлснээр мөнгө угаах гэсэн хэллэг, ойлголт үүссэн байна. Олон улсын валютын сангийн тооцооллоор дэлхий даяар дотоодын нийт бүтээгдэхүүний 2-5 хувьтай тэмцэх хэмжээний хөрөнгө жил бүр угаагддаг, мөн мөнгө угаалт нь далд эдийн засгийг өөхшүүлдэг, авлигын үндэс суурь болдог, татварын суурийг багасгадаг зэрэг нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байх тул уг гэмт хэрэгтэй тууштай тэмцэх шаардлагатай. Олон улсын хэмжээнд НҮБ-аас гаргасан Палермогийн конвенц болон Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргасан зөвлөмж дээр суурилан улс орон бүр мөнгө угаахтай тэмцэж байна. Монгол Улсын хувьд ФАТФ-н гишүүн орон бөгөөд түүний зөвлөмжид заасны дагуу мөнгө угаахтай тэмцэх бүтцийг бүрдүүлэн, заагдсан ажлуудыг хийж гүйцэтгэх замаар мөнгө угаахтай тэмцэж байна.

Мөнгө угаах үйлдлийн талаар дараах чиглэлд судалгаа хийгдсэн байна. Үүнд: (а) Мөнгө угаахтай тэмцэх бүтэц ба түүний үр нөлөө: судлаачид Мөнгө угаахтай тэмцэх бүтэц, ФАТФ-н гаргасан зөвлөмжийг шүүмжилсэн ба түүний үр нөлөөнд анхаарлаа хандуулсан; (б) Мөнгө угаах гэмт хэргийн бусад салбар болон эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: мөнгө угаах гэмт хэрэг нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг гэж дүгнэсэн; (в) мөнгө угаах үйлдлийн хүрээ: жил бүр дотоодын нийт бүтээгдэхийн 2-5 хувьтай тэмцэх хэмжээний хөрөнгө угаагддаг гэж дүгнэсэн; (г) мөнгө угаах шинэ боломжууд: технологийн болон хяналтын өөрчлөлтөөс шалтгаалан мөнгө угаах шинэ технологиудыг хөгжихөд түлхэц өгсөн байна; (д) мөнгө угаалтыг илрүүлэх: мөнгө угаалтыг автоматаар илрүүлэх чиглэлээр хэд хэдэн загварууд боловсруулсан байна.

Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд нь нягтлан бодогч, санхүүгийн мэргэжилтнийг ашиглах тохиолдол түгээмэл бөгөөд санхүүгийн системд аливаа мөнгөн хөрөнгө нэвтрэн орохдоо эхлээд нягтлан бодогчд нараар дамждаг байна. Тиймээс ФАТФ-ын Зөвлөмж 22, Мөнгө угаах болон Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.9-т нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нарыг мөнгө угаах зорилгоор хийгдэж байж болзошгүй сэжигтэй гүйлгээ, үйлдлийн талаар мэдээлж байх талаар үүрэгжүүлсэн байдаг. Энэ нь Мөнгө угаахтай тэмцэх нь дан ганц хууль сахиулах байгууллагууд, хууль зүйн салбарын асуудал биш олон салбарын хамтын ажиллагаа, тэр дундаа санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн салбар, нягтлан бодогч, аудитор, санхүүгийн шинжээч нарын анхаарах асуудал мөн гэдгийн илрэл юм.

Монгол Улсын хувьд мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр санхүү, эдийн

засаг, нягтлан бодох бүртгэлийн салбарт хийгдсэн судалгааны ажил харьцангуй бага, цаашид уг гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд судалгаа шинжилгээ хийх шаардлагатай байна. Тухайлбал мөнгө угаасан байж болзошгүй сэжигтэй гүйлгээг автоматаар илрүүлэх, мөнгө угааж болзошгүй эрсдэлийг үнэлэх санхүүгийн загвар боловсруулах, эдийн засгийн шинжилгээ хийх чиглэлд судалгааны ажил үгүйлэгдэж байна.

Ашигласан материал

- [1] Төрболд Э, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх Монгол улсын үйл ажиллагаа: Магистрын зэрэг горилсон судалгааны ажил
- [2] Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан: https://shuukh.mn/single_case/39520?daterange=2019-01-01%20-%202019-12-12&id=1&court_cat=2&bb=1
- [3] Alberto, G. S. (2016), “Spain: financial ownership file and money laundering prevention”, *Journal of Money Laundering Control*, Vol. 19 No. 3, pp. 238-248.
- [4] Alvarez-Jareno, J. A., Badal-Valero, E., & Pavia, J. M. (2017). Using machine learning for financial fraud detection in the accounts of companies investigated for money laundering. *Economics department Universitat Jaume*, 3-21.
- [5] Aurasu, A. and Aspalella, A. R. (2018), “Forfeiture of criminal proceeds under anti-money laundering laws: A comparative analysis between Malaysia and United Kingdom (UK)”, *Journal of Money Laundering Control*, Vol. 21 No. 1, pp. 104-111.
- [6] Barone, R. and Schneider, F. G. (2018), “Shedding Light on Money Laundering. Is It a Damping Wave?”, *SSRN Electronic Journal*.
- [7] Bidabad, B. (2017), “Money laundering detection system (MLD) (a complementary system of Rastin banking)”, *Journal of Money Laundering Control*, Vol. 20 No. 4, pp. 354-366.
- [8] Botes, V. and Saadeh, A. (2018), “Exploring evidence to develop a nomenclature for forensic accounting”, *Pacific Accounting Review*, Vol. 30 No. 2, pp. 135-154.
- [9] Bozhilova, K. (2018), “European Union: European Commission Proposes New Anti-Money Laundering Directives”.
- [10] Breiman, L. (2001). Random forests. *Machine learning*, 5-32.
- [11] Buchanan, B. (2004), “Money laundering—a global obstacle”, *Research in International Business and Finance*, Vol. 18 No. 1, pp.

- 115-127.
- [12] Camdessus, M. (1998), "Money laundering: the importance of international countermeasures", in Plenary Meeting of the Financial Action Task Force on Money Laundering, Paris.
 - [13] Chang, R., Lee, A., Ghoniem, M., Kosara, R., Ribarsky, W., Yang, J., Suma, E., Ziemkiewicz, C., Kern, D. and Sudjianto, A. (2008), "Scalable and Interactive Visual Analysis of Financial Wire Transactions for Fraud Detection", *Information Visualization*, Vol. 7 No. 1, pp. 63-76.
 - [14] Choo, K. K. R. (2015), "Cryptocurrency and Virtual Currency: Corruption and Money Laundering/Terrorism Financing Risks?", *Handbook of Digital Currency*, Academic Press, San Diego, pp. 283-307.
 - [15] Chu, H., Lai, C. C. and Cheng, C. C. (2015), "Tax Havens, Growth, and Welfare", *Journal of Public Economic Theory*, Vol. 17 No. 6, pp. 802-823.
 - [16] Colladon, A. F., & Remondi, E. (2017). Using social network analysis to prevent money laundering. *Expert systems with Applications*, 49-58.
 - [17] David Mathuva, Samuel Kiragu, Dulacha Barako, *Journal of Money Laundering Control*, The determinants of corporate disclosures of anti-money laundering initiatives by Kenyan commercial banks , ISSN: 1368-5201, 2020
 - [18] Dharmapala, D. (2008), What problems and opportunities are created by tax havens? *Oxford Review of Economic Policy*, 24(4), 661–679.
 - [19] Dostov, V. and Shust, P. (2014), "Cryptocurrencies: an unconventional challenge to the AML/CFT regulators?", *Journal of Financial Crime*, Vol. 21 No. 3, pp. 249-263.
 - [20] Dowers, K. and Palmreuther, S. (2003), "Developing an international consensus to combat money laundering and terrorism financing", *Infrastructure and Financial Markets Review*, Vol. 9 No. 1, pp. 1-7.
 - [21] Drayton, F. R. (2002), "Dirty Money, Tax and Banking: Recent Developments Concerning Mutual Legal Assistance and Money Laundering in the Caribbean Region and the Region's Responses", *Journal of Money Laundering Control*, Vol. 5 No. 4, pp. 338-344.
 - [22] Floris, V. (2020), "Detection of money laundering transaction network structures and typologies using machine learning techniques", Master Thesis, Erasmus school of economics
 - [23] Hendriyetty, N. and Grewal, B. S. (2017), "Macroeconomics of money laundering: effects and measurements", *Journal of Financial Crime*, Vol.

- 24 No. 1, pp. 65-81.
- [24] Jakobi, A. P. (2018), "Governing illicit finance in transnational security spaces: the FATF and anti-money laundering", *Crime, Law and Social Change*, Vol. 69 No. 2, pp. 173-190.
- [25] Khan, N. S., Larik, A. S., Rajput, Q., & Haider, S. (2013). A Bayesian approach for suspicious financial activity reporting. *International Journal of Computers and Applications*, 181-187.
- [26] Liu, R., Qian, X.-l., Mao, S., & Zhu, S.-z. (2011). Research on anti-money laundering based on core decision tree algorithm. *Chinese Control and Decision Conference*, 4322- 4325.
- [27] Lv, L.-T., Ji, N., & Zhang, J.-L. (2008). A RBF Neural Network Model for Anti-Money Laundering. *Wavelet Analysis and Pattern Recognition*, 209-215.
- [28] Mitchell, A., Sikka, P. and Willmott, H. (1998a), *The Accountants' Laundromat*, Basildon: Association for Accountancy & Business Affairs.
- [29] Mitchell, A., Sikka, P. and Willmott, H. (1998b), "Sweeping it under the carpet: The role of accountancy firms in moneylaunders", *Accounting, Organizations and Society*, Vol. 23 No. 5, pp. 589-607.
- [30] Ngai, E. W. T., Hu, Y., Wong, Y. H., Chen, Y. and Sun, X. (2011), "The application of data mining techniques in financial fraud detection: A classification framework and an academic review of literature", *Decision Support Systems*, Vol. 50 No. 3, pp. 559-569.
- [31] Norton, S. D. (2018), "Suspicion of money laundering reporting obligations: Auditor compliance, or sceptical failure to engage?", *Critical Perspectives on Accounting*, Vol. 50, pp. 56-66.
- [32] Picard, P. M. and Pieretti, P. (2011), "Bank secrecy, illicit money and offshore financial centers", *Journal of Public Economics*, Vol. 95 No. 7, pp. 942-955.
- [33] Pol, R. (2018a), "Anti-money laundering effectiveness: assessing outcomes or ticking boxes?", *Journal of Money Laundering Control*, Vol. 21 No. 2, pp. 215-230.
- [34] Pol, R. (2018b), "Uncomfortable truths? ML=BS and AML= BS2", *Journal of Financial Crime*, Vol. 25 No. 2, pp. 294-308.
- [35] Ravenda, D., Valencia, M. M., Josep, M. A. and Josep, G. B. (2017), "Accrual management as an indication of money laundering through legally registered Mafia firms in Italy", *Accounting, Auditing & Accountability Journal*, Vol. 31 No. 1, pp. 286-317.
- [36] Schwarz, P. (2011), "Money launderers and tax havens: Two sides of the same coin?", *International Review of Law & Economics*, Vol. 31

- No. 1, pp. 37-47.
- [37] Slemrod, J. (2008). Why is Elvis on Burkina Faso postage stamps? Cross-national evidence on the commercialization of state sovereignty. *Journal of Empirical Legal Studies*, 5, 683–712.
- [38] Tang, J., & Yin, J. (2005). Developing an intelligent data discriminating system of antimoney laundering based on SVM. *Machine Learning and Cybernetics*, 3453-3457.
- [39] Thoumi, F. E. (2005), “The numbers game: let’s all guess the size of the illegal drug industry!”, *Journal of Drug Issues*, Vol. 35 No. 1, pp. 185-200.
- [40] Turner, A. and Irwin, A. S. M. (2018), “Bitcoin transactions: a digital discovery of illicit activity on the blockchain”, *Journal of Financial Crime*, Vol. 25 No. 1, pp. 109-130.
- [41] Unger, B. (2013), “Can Money Laundering Decrease?”, *Public Finance Review*, Vol. 41 No. 5, pp. 658-676.
- [42] Walker, J. (1999), “How Big is Global Money Laundering?”, *Journal of Money Laundering Control*, Vol. 3 No. 1, pp. 25-37.
- [43] Zdanowicz, J. S. (2004a), “Detecting money laundering and terrorist financing via data mining”, *Communications of the ACM*, Vol. 47 No. 5, pp. 53-55.
- [44] Zdanowicz, J. S. (2004b), “U.S. Trade with the World and Al Qaeda Watch List Countries - 2001: An Estimate of Money Moved Out of and Into the U.S. Due to Suspicious Pricing in International Trade”.
- [45] Zdanowicz, J. S. (2009), “Trade-based money laundering and terrorist financing”, *Review of Law and Economics*, Vol. 5 No. 2, pp. 855-878.
- [46] Zhang, Z., Salerno, J. J. and Yu, P. S. (2003), “Applying data mining in investigating money laundering crimes”, in *Proceedings of the ACM SIGKDD International Conference on Knowledge Discovery and Data Mining*, pp. 747-752.
- [47] Ревенков, П.В. Финансовый мониторинг: управление рисками отмывания денег в банках / П.В. Ревенков, А.Б. Дудка, А.Н. Воронин, М.В. Каратаев. - Москва : КноРус, 2012. - 279 с. - ISBN 978-5-406-02164-4.

ЭНТРЕПРЕНЕР ИХ СУРГУУЛЬ: ИХ СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ЭНТРЕПРЕНЕР ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Д.Батцэцэг*, Н.Батдэлгэр**

Хураангуй: Их сургууль энтрепренершип чиг баримжаатай хөгжихөд багш нар гол тоглогч байдаг. Энэ утгаараа их сургуулийн багш нарын энтрепренер болох зорилго, зан төлөв, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах, судалгааны үр дүнд тулгуурлан оновчтой бодлого зохицуулалтыг хийх шаардлагатай байдаг. Энэхүү судалгаа нь МУ-ын их сургуулиудын багш нарын энтрепренер болох зорилгод нөлөөлөх сэтгэлзүйн болон эдийн засгийн хүчин зүйлсийг судласан бөгөөд нийт 16 сургуулийн 371 багш судалгаанд оролцсон. Судалгаагаар багш нарын энтрепренер болох зорилгод сэтгэлзүйн болон эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөлөл, шууд болон шууд бус хамаарлын шинжилгээний үр дүнг харуулахыг зорьсон. Их сургуулийн багш нарын энтрепренер болох зорилгод энтрепренершипт хандах хандлага, зан төлвийн хяналт, нийгмийн хэм хэмжээ шууд нөлөөлж байгаа үр дүн гарсан. Харин эдийн засгийн үзүүлэлтийн нэг болох хүлээгдэж буй үр өгөөж нь хандлага, зан төлвийн хяналтыг нэмэгдүүлэх замаар энтрепренер болох сэдэлд нөлөөлж байсан. Энэ үр дүнгээс багш нарын энтрепренер болох зорилгыг сэдэлжүүлэхийн тулд тэдний хандлага, зан төлвийг гүйцэтгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдсан. Мөн судалгаагаар багш нарын энтрепренершип үйл ажиллагаанд оролцоход саад болж байгаа хүчин зүйлсийг тодруулахад “урамшуулалын систем сул”, “санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай” гэсэн үзүүлэлт хамгийн их санал авсан болно.

Түлхүүр үгс: Энтрепренершип, энтрепренер их сургууль, энтрепренер болох зорилго

ENTREPRENEURIAL UNIVERSITY: A STUDY TO DETERMINE THE ENTREPRENEURIAL INTENTION OF TEACHERS IN HIGHER EDUCATION INSTITUTE

Abstract: Teachers are the key players in development of the entrepreneurial university. Regarding this concept, a specific analysis has been needed to investigate academics' intention and behavior to execute adequate policy that triggers an entrepreneurial environment based on the research results. This paper aims to identify psychological and economic factors that influence teachers' entrepreneurial intention. Teachers (n=371) in higher education institutes were involved in this survey which has not been taken before in the Mongolian context. The theory of planned behavior and economic models is adopted to this study highlighting direct and indirect factors correlated to entrepreneurial intention. We found that attitudes to entrepreneurship, perceived behavior control and social norms are predicted entrepreneurial intentions. The expected benefits exhibited indirect effects on intentions via entrepreneurial attitudes and perceived behavioral control. Another result showed that the most recurring barriers to involve entrepreneurship activities were “a weak incentive system” and “lack of financial resources”

Keywords: Entrepreneurship, entrepreneurial university, entrepreneurial intention

¹ ХҮИС, (E-mail): dalkhbattssetseg@gmail.com

² МУИС, Бизнесийн сургууль (E-mail): batdelger.n@num.edu.mn

Удиртгал

Сургалт, судалгааны ажлын үр дүнгээр нийгэмд өөрсдийн үнэ цэнийг бий болгож, өрсөлдөх чадвараа харуулж байдаг их сургуулиудын өмнө шинэ чиг үүрэг нэмэгдэх болжээ. Бүтээж буй мэдлэг, хийж буй судалгааны ажлын ололт, амжилтууд нь шинжлэх ухаанд суурилсан байдаг учир мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийн гол тоглогч нь яахын аргагүй их сургууль болж байна.

Их сургууль төрөлхийн инкубатор (Shumpeter, 1934) болохын учир шинжлэх ухаанд суурилсан судалгаа, туршилтын үр дүнд шинэ дэвшилтэт технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож байдаг. Иймд эрдэмтэд, судлаачдын судалгааны үр дүнд бий болсон оюуны бүтээлүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хэрэглээг бий болгох, зах зээлд хүргэх дотоод, гадаад таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх нь их сургуулиудын өмнө тулгарч буй чухал асуудлуудын нэг болж байна. Оюуны бүтээл төрөхөөс эцсийн бүтээгдэхүүн болон гарах хүртэл үйл ажиллагааг зөв зохицуулах, удирдах хүрээнд их сургуулиудын өмнө шинэ сорилтууд бий болж, тэд бизнесийн байгууллагын зарим чиг үүргийг хүлээх болсон. Үүнийг дэлхий нийтэд “академик энтрепренершип”, “энтрепренер их сургууль” гэх мэтээр нэрлэж дээд боловсролын хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж байна.

Шинжлэх ухааны шинэ мэдлэгийг зах зээлд хүргэх шууд суваг бол академик энтрепренершип (Shane, 2004) бөгөөд эрдэмтэд өөрсдийн бий болгосон шинэ, өвөрмөц технологи бүхий бүтээгдэхүүнийг зах зээлд хүргэхийн тулд их сургуулийнхаа дэргэд компани байгуулснаар “энтрепренер эрдэмтэн” болдог. Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний үр дүнд бий болсон шинэ технологи, шинэ бүтээгдэхүүнд үндэслэн гарааны компаниуд олноор төрөн гарах нь бүс нутаг, улс орны хөгжилд хувь нэмэр оруулах, эдийн засгийн үр ашгийг хүргэх асар их ач холбогдолтой.

Энтрепренершипийн тухай дээрх гол бүтээлүүд нь 1) энтрепренер хүн, 2) түүний өндөр үр ашиг бүхий шинэ, өвөрмөц санааг бодит бизнес болгоход дэмжих институциудын үйл ажиллагаа, 3) орчны нөхцөл байдлын хоорондын уялдаа холбоо, харилцан хамааралыг олон талаас нь судлаж энтрепренершипийг хөгжүүлэхийн ашиг тусыг онцлон тэмдэглэсэн байдаг. Эдгээр судалгааны ажлуудтай зэрэгцэн нийгэм болон сэтгэлзүйн шинжлэх ухааны үндсэн ойлголтуудыг энтрепренершип үйл ажиллагаатай холбон тайлбарлаж байгаа бас нэг бүлэг судалгаа бий. Энэ нь хувь хүнийг энтрепренер болох, энтрепренер үйл ажиллагаанд оролцох *сэдэл, зорилго, зан төлөв, шийдвэр гаргалтад* нөлөөлж буй хүчин зүйлсүүдийн судалгаа юм.

Энтрепренер зан төлвийн судалгааны бүтээлүүд нь хувь хүнийг энтрепренер

болоход өдөөх дотоод болон гадаад хүчин зүйлс тэдгээрийн нөлөөлийг тайлбарласан байдаг. Дотоод нөлөөлөл нь бодитоор хэмжих боломжгүй боловч хувь хүний зан төлөв, шийдвэр гаргалтад маш хүчтэй нөлөө үзүүлдэг сэтгэлзүйн хүчин зүйлс байдаг бол гадаад нөлөөлөл нь бодитоор хэмжих боломжтой, нөлөөлөлийн хүч нь харилцан адилгүй байдаг нийгмийн дэмжлэг, цалин урамшуулал, ажлын орчин, нөхцөл гэх мэт хүчин зүйлсүүд байна. Жишээ нь: худалдан авалтад хувь хүний хандлага, зан төлөв хэрхэн нөлөөлж байгааг шууд хэмжих боломжгүй, харин худалдан авалтад нөлөөлсөн бүтээгдэхүүний чанар, үнэ, орчны нөхцөл байдлыг хэмжих боломж харьцангуй өндөр. Эндээс хувь хүний дотоод сэтгэлийн хүчин зүйлс, гадаад орчны хүчин зүйлстэй хоршин байж эцсийн шийдвэр гардаг гэсэн дүгнэлтэд хүрч болох юм бөгөөд хувь хүний бизнес эрхлэх сэдэлд дотоод хүчин зүйлс эсвэл гадаад орчны таатай нөхцөл нөлөөлж байна уу гэдэг нь салбарын судалгааны сонирхолтой сэдэв байсаар байна.

Зан төлвийн хандлагаар энтрепренерүүдийн өвөрмөц онцлогийг судлахын тулд шинэ бизнес эхлүүлэх процессыг судлах ингэснээр тухайн процессын туршид шаардагдах зан төлвүүдийг таамаглаж болох (Gartner, 1989) ба энэ нь байгуулагын орчинд энтрепренер зан төлвийг илрүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад тустай болохыг тайлбарладаг. Тэд энтрепренер зан төлвийг гүйцэтгэхэд нөлөөлөх хүчин зүйл, урьдач нөхцөл юу байх вэ? гэдэг асуултад хариулахын тулд өөрсдийн таамаглалыг дэвшүүлж батлах оролдлогуудыг хийж ирсэн. Харин нийгмийн сэтгэл судлалын салбарын судлаачид “зорилго” бол хүний зан төлвийг таамаглах хамгийн чухал хүчин зүйл гэж тайлбарладаг. Өөрөөр хэлбэл хувь хүн өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн төлөө тодорхой зан төлвүүдийг хэрэгжүүлдэг байна. (Ajzen, 1991)-ны тодорхойлсноор хувь хүнийг тодорхой зорилгод өдөөх хүчин зүйлс бол тэдний хандлага, нийгмийн хэм хэмжээ, төсөөлөгдсөн зан төлвийн хяналт зэрэг байдаг. Тэгэхээр академик түвшинд буюу их сургуулийн профессор, багш нарын энтрепренер зан төлөвт нөлөөлөх хүчин зүйлсийг судлах, үр дүнд шинжилгээ хийх нь мэдлэгийг арилжаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах дараа дараагийн ажлуудын суурь болох юм.

Бидний энэ удаагийн судалгааны ажил нь МУ-ын дээд боловсролын салбарт ажиллаж буй профессор, багш, судлаачдын энтрепренер болох зорилго /сэдэл/-ийг тодорхойлохыг зорьлоо. Манай улсад их сургуулийн багш нарын энтрепренерт чиглэсэн хандлага, зорилгыг тодорхойлсон судалгаа маш ховор байдаг. Энэхүү судалгааны үр дүнд Монгол улсын их сургуулиуд “энтрепренер сургууль”-ийн үзэл баримтлалаар хөгжих суурь нөхцөл болох багш, судлаачдын сэтгэлзүйн бэлэн байдал, зан төлвийг тодорхойлох боломжтой болно.

1. Онолын үндэслэл

Энтрепренер их сургуулийн гол үзэл баримтлал нь профессор, багш нар судалгааны хил хязгаараа өргөжүүлж аж үйлдвэр, бизнесийн байгууллагуудтай хамтарсан судалгаа хийх, судалгааны үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэх, мөн өөрсдийн бүтээл, нау хау-д тулгуурлан патент эзэмших, ашиглуулах, шинэ бизнес эрхлэх боломжтой байдагт оршино. Эрдэмтэд, багш нар “энтрепренер” байх, энтрепренершип үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нь зөвхөн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх гэхээс илүүтэй суралцаж буй оюутнууд болон байгууллагын бусад гишүүдэд энтрепренер зан төлөв, сэтгэлгээ, зөв соёлыг төлөвшүүлэхэд өөрсдөө үлгэр дуурайлал болдог төдийгүй нийгэмд энтрепренершиппийг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг байна. Тиймээс Америк, Европ, Азийн их сургуулиуд академик энтрепренершиппийг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна. Их сургууль энтрепренер чиг баримжаатай хөгжснөөр дараах үр дүн гарахыг эрдэмтэд судалгаагаар нотлосон байдаг. Үүнд: Засаглалын хувьд бие даасан байх, санхүүжилтийн олон эх үүсвэртэй болох, аж үйлдвэртэй ойр хамтын ажиллагаатай байх, их сургуулийн багш, профессорууд патент эзэмших, оюуны өмчөө арилжаалах хүсэл эрмэлзэлтэй болох, байгууллагын бүхий л түвшинд энтрепренер соёл төлөвших, энтрепренершип үйл ажиллагааг дэмжих дэд бүтэц хөгжих гэх мэт.

Дээр дурьдсанчлан их сургуулийн энтрепренер чиг баримжаатай хөгжлийн түлхүүр тоглогчид бол багш, судлаачид байдаг. Тиймээс ч олон улсад эрдэмтэд их сургуулийн профессор багш нарын энтрепренершип үйл ажиллагаанд хандах хандлага, тэдний энтрепренер байх хүсэл эрмэлзэл, зорилгыг тодорхойлж, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг маш олон талаас нь судлаж, үр дүнг танилцуулсаар ирсэн байна. Бидний энэхүү судалгаа нь МУ-ын их сургуулийн багш нарын дунд явуулсан, тэдний “энтрепренер зорилго”-ыг тодорхойлох анхны судалгаа болж байгаагаараа ач холбогдолтой юм. Судалгаа хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ; эхний хэсэгт энтрепренер болох сэдэлд нөлөөлөх сэтгэлзүйн хүчин зүйлс, хоёрдугаар хэсэгт эдийн засгийн хүчин зүйлс, тэдгээрийн нөлөөллийг тус тус харуулсан болно.

1.1 Энтрепренер байх зорилгыг сэдэлжүүлэх сэтгэлзүйн хүчин зүйлс

Энтрепренер байх зорилго - *Entrepreneurial Intention (EI)*: Хувь хүн шинэ бизнес эрхлэх шийдвэр гаргасны дараа энтрепренер үйл ажиллагаа эхэлдэг (Saeid Karimi, 2017). Тиймээс энтрепренершиппийг хөгжүүлэхийн тул хувь хүний бизнес эрхлэх сэдлийг төрүүлж буй учир шалтгаан, шийдвэр гаргалтад нөлөөлж буй хүчин зүйлсийг ойлгох нь чухал юм. Эрдэмтэн Bird

(1988), энтрепренер байх нь хувь хүний зорилгоос эхтэй ба энэхүү зорилго нь энтрепренер зан төлвийг гүйцэтгэх урьдчилсан нөхцөл болдог, Saeid Karimi (2017) энтрепренер болох зорилго нь шинэ бизнес эхлүүлэх процессын хамгийн эхний алхам бөгөөд энтрепренершип бол төлөвлөгдсөн зан төлвийн үр дүн гэж ойлгож болно гэж тус бүр дүгнэсэн байдаг. Харин Fishbein and Ajzen (2010) нар институцийн орчинд хувь хүний үүрэг, даалгаврын талаарх ойлголт, үүргээ гүйцэтгэх итгэл үнэмшлээр дамжуулан тэдний зорилгод нөлөөлж болохыг тайлбарласан. Энэ нь байгууллагын орчинд ажилчдад / гишүүдэд/ “энтрепренер” байх хүсэл эрмэлзэл, итгэл үнэмшил, шинэ бизнес эрхлэх сэдлийг төрүүлж болохыг харуулж байгаа юм.

Энтрепренер болох зорилгыг тодорхойлох судалгааны ажлууд ихэвчлэн (Ajzen, 1991) төлөвлөгдсөн зан төлвийн онол (ТРВ) дээр суурилсан байдаг. Төлөвлөгдсөн зан төлвийн онолоор хувь хүний зорилго нь тэдний зан төлвөөр илрэх бөгөөд хандлага, зан төлвийн хяналт, нийгмийн хэм хэмжээ гэсэн гурван бие даасан хүчин зүйлээр нөхцөлддөг гэж тайлбарладаг. Тэгэхээр өмнөө тавьсан зорилгоор нь хүний тодорхой зан төлвийг гүйцэтгэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлтыг таамаглах боломжтой бөгөөд тухайн зан төлвийг гүйцэтгэх хүсэл эрмэлзэл хэдий чинээ их байна, гүйцэтгэл төдий чинээ хүчтэй байдаг (Ajzen, 1991) байна.

Энтрепренершипт хандах хандлага- Attitudes to entrepreneurship (ATE): Байгууллагын зан төлвийн шинжлэх ухаанд хандлагыг “тодорхой зорилгод, хүмүүст, үйл хөдлөлд өгч байгаа хувь хүний үнэлгээ” буюу аливаа зүйлийг “сайн, муу”, “таатай, таагүй” гэж үзэх үнэлэмж гэж тодорхойлдог. Мөн хандлага нь хувь хүний зан төлөв, үйл хөдлөлд эерэг болон сөрөгөөр нөлөөлдөг гэж тайлбарладаг. Аливаа зүйлд хандах хандлагад хүний сэтгэлзүйн байдал, эзэмшсэн мэдлэг, боловсрол, ур чадвар, итгэл үнэмшил, хүрээлэн буй орчин, нөхцөл, хүмүүс хоорондын харилцаа гэх мэт олон хүчин зүйлс нөлөөлдөг. Эндээс энтрепренер байх, үгүй нь тухайн хүний эерэг, сөрөг хандлагаас хамааран өөрчлөгддөг гэсэн дүгнэлтэд хүрч болно. Тэгвэл профессор, багш нарын “энтрепренер” болох хүсэл эрмэлзэл нь тэдний судалгааны ажлын үр дүн зах зээлд хүрч, эдийн засгийн үр ашгаа өгнө гэсэн итгэлээр бий болж цаашлаад энтрепренершипт хандах хандлагад эерэгээр нөлөөлдөг байна (Saeid Karimi H. J., 2017), (M. Goethner, 2012), (Martin Obschonka, 2012), (Francisco Licbn, 2009).

Төсөөлөгдсөн зан төлвийн хяналт- Perceived behavioral control (PBC): Энэ нь хувь хүн өөрийгөө ямар нэг зорилгын биелүүлж чадна, чадахгүй гэсэн төсөөлөл хэмээн ойлгож болно. (Ajzen, 1991)-ынхаар төсөөлөгдсөн зан төлвийн хяналт нь хүн аливаа зүйлийг гүйцэтгэхдээ түүнийг хялбар эсвэл хэцүү гэж

хүлээн авах байдлаар илэрхийлэгдэнэ. Төсөөлөгдсөн зан төлвийн хяналт нь (Bandura, 1997) төсөөлөгдсөн өөрийн үнэлэмж (perceived self-efficacy) онолтой ижил утгатай бөгөөд тодорхой нөхцөл байдалд гүйцэтгэх шаардлагатай үүрэг даалгаваруудыг хир сайн биелүүлж чадах эсэхэд дүгнэлт өгч буй хувь хүний өөрийн үнэлэмж юм.

Нийгмийн хэм хэмжээ-Social norm: Энэ ойлголт нь хувь хүний зан төлөв нийгмийн тодорхой бүлгийн нөлөөллөөр өөрчлөгдөж байдгийг тайлбарладаг бөгөөд нийгмийн харилцааны үндэс бол нийгмийн хэм хэмжээ байдаг. Гэр бүл, найз нөхөд, хамт олон зэрэг нийгмийн тодорхой бүлгүүдэд тогтсон уламжлал, зан заншил, соёл зэрэг хүчин зүйлүүд хувь хүний зан төлвийн гүйцэтгэлд эерэг болон сөргөөр нөлөөлдөг. Харин академик энтрепренершипийн хүрээнд их сургуулийн профессор, багш нарын шинэ бизнес эхлүүлэх сэдэл нь байгууллагын зорилго, төлөвлөгөө, дүрэм журам, хамт олны дэмжлэг, гарааны бизнес эрхэлсэн сайн туршлага, хамт олны гишүүдийн мэдлэгийг арилжаалах, дамжуулах процесст оролцож буй байдал (Rahm, 1994), амжилттай яваа энтрепренерүүдийн үлгэр дуурайлал (Nanda, 2010), (Huyghe, 2015), урамшуулал зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр идэвхждэг байна.

1.2 Энтрепренер байх зорилгыг сэдэлжүүлэх эдийн засгийн хүчин зүйлс

Их сургуулийн профессор, багш, оюутнуудыг хамтарсан судалгаа хийх боломжоор хангах, технологи шингэсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, улмаар гарааны компаниудыг олноор төрүүлэн гаргах нь академик энтрепренершипийн гол агуулга юм. Институцийн бүхий л түвшинд энтрепренер соёлыг төлөвшүүлэхийн ач холбогдол нь бий болох нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг хүртэх байдаг. Энтрепренершипыг тодорхойлох эдийн засгийн хүчин зүйлсээр хүмүүн болон нийгмийн капиталын хувьсагчуудыг авч үздэг.

Хүмүүн капитал – Human Capital (HC) Хүмүүн капиталын онолоор хүмүүс амьдралынхаа туршид эдийн засгийн үр ашгаа нэмэгдүүлэх хүсэл эрмэлзэлтэй байдаг ба өөрсдийн мэдлэг, ур чадварт оруулсан хөрөнгө оруулалтынхаа өгөөжийг хүлээж байдаг хэмээн тайлбарладаг. Үүнийг энтрепренершиптэй холбовол энтрепренерүүд шинэ бизнесийн үйл ажиллагаанаасаа санхүүгийн ашиг олохыг хичээдэг бөгөөд энэ тэдний өөрсдийн мэдлэг, чадварт оруулсан хөрөнгө оруулалттай хамааралтай байдаг. Тэгэхээр энтрепренерүүдийн мэдлэг, ур чадвар нь бизнесийн өсөлттэй эерэг хамааралтай байх ёстой (Cassar, 2006).

(Unger, 2011) нар хүмүүн капитал гэдгийг хувь хүний сургууль, ажлын байран дээрх сургалт болон бусад төрлийн туршлага, тэдгээрт зориулсан хөрөнгө

оруулалтаараа олж авсан мэдлэг, ур чадваруудыг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Харин (Becker, 1964) үүнийг тайлбарлахдаа *хүмүүн капиталын хөрөнгө оруулалт* /human capital investment/ болон *хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын үр дүн* /outcomes of human capital investment / гэж 2 ангилж үзсэн байдаг. Тэрээр хүмүүн капиталын хөрөнгө оруулалт гэдэгт боловсрол, туршлага зэргийг, хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын үр дүн гэдэгт мэдлэг, ур чадвар гэсэн ойлголтуудыг хамруулсан байдаг. Үүнээс гадна *үрэг даалгаварт чиглэсэн хүмүүн капитал* /task related human capital/ гэсэн ойлголт байх ба энэ нь тодорхой үүрэг даалгаварт чиглэсэн хүмүүн капиталын хөрөнгө оруулалт болон бий болох үр дүнг хэлдэг. Өөрөөр тайлбарлавал технологийн старт-апуудыг бий болгохын тулд олгож буй сургалт, туршилт, лаборатори ажлууд тэдгээрийн үр дүнд бий болж буй мэдлэгтэй, чадвартай бизнес эрхлэгч, шинэ санаа бүхий патент эзэмшигчдийг хамруулан ойлгож болно.

Тэгвэл хүмүүн капиталын хөрөнгө оруулалтын үр дүн болох энтрепенер мэдлэг, чадварыг хэрхэн тодорхойлох вэ? Эрдэмтэн (Shane and Venkataraman, 2000) нар хувь хүний боломжийг олж харах, таних, ашиглах чадваруудыг “энтрепенер чадавхи” гэж тодорхойлсон байдаг. Энтрепенер чадавхи өндөртэй эрдэмтэд спин-офф, старт-ап үүсгэн байгуулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог бөгөөд нэг удаа бизнес эхлүүлэх үйл ажиллагаанд оролцсон эрдэмтэн өмнөх үр дүнгээ үл харгалзан дараагийн оролдлогуудыг хийсээр байдаг (Bart Claryssea, Valentina Tartari et.al). Өөрөөр хэлбэл нэгэнт шинэ бизнес байгуулахад оролцсон хүн юу хүсэж байгаагаа мэддэг бөгөөд өөрийн ур чадвараа илүү үнэлж чаддаг. Тэгэхээр их сургууль дахь хүмүүн капиталын үнэ цэнэ, чадавхийг эрдэмтдийн шинжлэх ухааны туршилт, ололт, төрөл бүрийн судалгааны үр дүнгээр хэмжих боломжтой. Энэ утгаар нь (M. Goethner, 2012) нар судалгааны үр дүнд бий болсон оюуны өмчөө баталгаажуулан патент эзэмшсэн байдал болон энтрепенер туршлага (өмнө нь шинэ бизнес эхлүүлэхэд оролцож байсан эсэх) гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан хүмүүн капиталыг хэмжсэн байдаг. Бидний хувьд их сургуулийн эрдэмтэд, багш нарын боломжийг олж харах, ашиглах чадварыг тэдний патент эзэмшсэн байдлаар хэмжиж үр дүнг харахыг зорьсон болно.

- *Патент* - Их сургуулийн профессор, багш нарын энтрепенер (оюуны өмчөө арилжаалж бизнес эрхлэх) үйл ажиллагааг тэдний эзэмшиж буй патентаар тодорхойлж болох юм. Патент бол оюуны өмчийн бодлогоор зохицуулагддаг судалгаа, хөгжлийн үр дүнд бий болдог бөгөөд патентад тавигдах ерөнхий шаардлага нь үйлдвэрлэлд ашиглагдах шинэ технологи, инновацийн бүтээгдэхүүн байдаг. Патент

эзэмших, мэдүүлэх нь судалгааны үр дүнгээ хамгаалах үйл ажиллагаа бөгөөд эрдэмтэд энтрепренершип үйл ажиллагаанд оролцох, аж үйлдвэрлэлтэй хамтран ажиллах суурь нөхцөл болдог.

Нийгмийн капитал – Social capital (SC) нь нийгмийн харилцаа буюу хувь хүн, бүлэг, байгууллагын хоорондын харилцаа холбоог багтаасан ойлголт (Liao, 2005). Нийгмийн капитал нь гарааны бизнес эрхлэх үйл ажиллагааны эхэн үеийн шийдвэр гаргалтуудад нөлөөлж байдаг онцлогтой. Нийгмийн харилцаа холбооны олон сувгууд шинэ бизнес эрхлэгчдэд: бизнес санаагаа хөгжүүлэх, хэрэгжүүлэх, илүү өргөн хүрээтэй харах боломж, шинэ бизнес эхлүүлэх хөрөнгө, санхүүжилтийн болон бусад чухал шаардлагатай дэмжлэг тусалцааг олж авах эх сурвалж болдог. Бизнесийн сайн харилцааг бий болгох мэргэжлийн форум (Virginia Fernandez-Perez, 2014), энтрепренершипийг дэмжих орчин (Berkowitz and Feldman 2008), (Bart Claryssea, 2011), технологи дамжуулах оффисын үйл ажиллагаа (Thursby, 2002) зэрэг хүчин зүйлс эрдэмтэдийг энтрепренершип үйл ажиллагаанд оролцох, шинэ бизнес эхлүүлэхэд чухал нөлөөтэй байдаг. Мөн гарааны бизнес эхлүүлэхэд шаардлагатай нөөцүүд болох мэдээлэл, ур чадвараар хангаж чадах хувийн сүлжээ, харилцаа холбоо сайтай энтрепренерүүд бизнес эхлүүлэх чадвартаа илүү итгэлтэй байдаг (Carr & Sequeira, 2007) байна. Иймээс бид их сургуулийн багш нарын нийгмийн сүлжээ, харилцаа холбоог судалгааны ажлын гол хувьсагчдын нэг болгон авч үзсэн.

Дээр өгүүлсэн хүмүүн болон нийгмийн капиталын үр нөлөөг сайн ойлгох нь шинжлэх ухаанч, эрдэмтдийн дунд энтрепренершипийг хөгжүүлэх боломж, нөөц хэр байгааг харуулах бөгөөд тэднийг энэ үйл ажиллагаанд татан оруулах оновчтой зохицуулалтуудыг хийх үндэс болж өгнө. Их сургуулийн хувьд аж үйлдвэрүүд, засгийн газар, түүний агентуудтай харилцаа холбоо сайтай байх нь профессор, багш нарын энтрепренер байх зорилгыг өдөөж идэвхжүүлдэг (Aldridge, 2011).

Хүлээгдэж буй үр өгөөж- Expected benefit (EB)

Эдийн засгийн үр ашиг талаас нь харсан ихэнх судалгаанууд хувь хүний тогтмол ажлаасаа энтрепренершип үйл ажиллагаанд шилжих шилжилт, энтрепренер байх зэрэг нь ирээдүйд хүртэх ашиг, үр өгөөжөөс хамаардаг болохыг харуулсан. Хувь хүн эрсдэл өндөртэй бизнес руу орох уу, эрсдэл багатай тогтмол цалинтай ажил дээрээ үлдэх үү гэх мэт олон сонголттой нүүр тулдаг бөгөөд ирээдүйд ирэх ашиг, орлого өндөр байвал эрсдэл үүрэхэд бэлэн (M. Goethner, 2012) байдаг. Харин их сургуулийн эрдэмтэд, багш нарыг энтрепренер байхад сэдэлжүүлэх хүчин зүйлсийг (Lam, 2010) “санхүүгийн урамшуулал-gold”, “нэр хүнд, карьерын урамшуулал-ribbon”, “дотоод сэтгэл

ханамж-puzzle” гэсэн гурван үзүүлэлтээр хэмжиж энтрепренер эрдэмтэд илүү санхүүгийн болон дотоод урамшуулалаар сэдэлжигддэг болохыг харуулсан бол (Davide Antonioli, 2016) нар “бусдын сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх”, “өөрийн нэр хүндийг өсгөх”, “ажлын хамт олонтой сайн харилцаа тогтоох” гэх мэт дотоод сэдэлжүүлэлтийн хүчин зүйлс эрдэмтдийг судалгааны ажлаа арилжаалах, шинэ бизнес эхлүүлэхэд хүргэдэг болохыг танилцуулсан байдаг. Бидний загвар болгон авсан М. Goethner (2012) нарын судалгаанд “академик нэр хүнд өсөх”, “хувийн орлого өсөх” гэсэн хоёр үзүүлэлтийг авч үзсэн байдаг. Бид дээрх хоёр үзүүлэлт дээр “багшлах ур чадвар өсөх”, “судалгааны ажлын чанар өсөх”, “их сургуулийн нэр хүнд өсөх” гэсэн үзүүлэлтүүдийг нэмж үр дүнг харахаар шийдсэн.

2. Судалгааны загвар, таамаглал, аргазүй

Бидний судалгаа (М. Goethner, 2012) -ын загвар дээр үндэслэсэн. Энэ загвар сэтгэлзүйн болон эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэгтгэн авч үзсэнээр бусдаас давуу талтай. Загвар 1-т үзүүлсний дагуу их сургуулийн эрдэмтэд, багш нарын бизнес эрхлэх зорилгод тэдний энтрепренершипт хандах хандлага, нийгмийн хэм хэмжээ, төсөөлөгдсөн зан төлвийн хяналт зэрэг хүчин зүйлүүд шууд болон эерэгээр нөлөөлнө. Харин хүмүүн болон нийгмийн капитал, энтрепренершипт хандах хандлага болон зан төлвийн хяналтаар дамжин энтрепренер болох зорилгод нөлөөлнө гэсэн таамаглалуудыг тус тус дэвшүүлсэн.

2.1 Судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн таамаглалууд:

Таамаглал 1a. Патент эзэмших байдал (Pat) энтрепренер болох зорилгод (EI) нөлөөлөх ба энтрепренершипт хандах хандлага (ATE) дундын хүчин зүйл болно.

Таамаглал 1b. Патент эзэмших байдал (Pat) энтрепренер болох зорилгод нөлөөлөх ба төсөөлөгдсөн зан төлвийн хяналт (PBC) дундын хүчин зүйл болно.

Таамаглал 2a. Нийгмийн капитал (SC) энтрепренер болох зорилгод (EI) нөлөөлөхөд энтрепренершипт хандах хандлага (ATE) дундын хүчин зүйл болно.

Таамаглал 2b. Нийгмийн капитал (SC) энтрепренер болоход зорилгод (EI) нөлөөлөх ба төсөөлөгдсөн зан төлвийн хяналт (PBC) дундын хүчин зүйл болно.

Таамаглал 3a. Хүлээгдэж буй өгөөж (EB) нь энтрепренер болох зорилгод


(EI) нөлөөлөх ба энтрепренишигт хандах хандлага (ATE) дундын хүчин зүйл болно.

Таамаглал 3b. Хүлээгдэж буй өгөөж (EB) нь энтрепренер болох зорилгод (EI) нөлөөлөх ба төсөөлөгдсөн зан төлвийн хяналт дундын хүчин зүйл болно.

Таамаглал 3c. Хүлээгдэж буй өгөөж (EB) нь энтрепренер болоход зорилгод (EI) эерэгээр нөлөөлнө.

Таамаглал 4. Энтрепренершигт хандах хандлага (ATE), Нийгмийн хэм хэмжээ (SN), төсөөлөгдсөн зан төлвийн хяналт (PBC) зэрэг нь энтрепренер болоход зорилгод (EI) шууд болон эерэгээр нөлөөлнө.

Загвар 1



Энтрепренер болох зорилгод шууд болон шууд бусаар нөлөөлөх хүчин зүйлс

Бид энтрепренер болох зорилгод шууд болон шууд бусаар нөлөөлөх хүчин зүйлс, тэдгээрийн нөлөөлөлийн хүч, ач холбогдлыг судлахаар судалгааны ажлынхаа таамаглалуудыг дэвшүүлж ажилласан.

Шууд бус нөлөөлөл

Энтрепренершигт хандах хандлагаар (ATE) дамжин энтрепренер зорилгод (EI) нөлөөлөх хүчин зүйлс

Хандлагыг өөрчилж болох уу?, тэр тусмаа энтрепренершигт хандах хандлагад хэрхэн эерэгээр нөлөөлөх вэ?. Эдгээр асуулттай холбоотой судлаачдын судалгааны үр дүнгээс танилцуулбал: (Nancy G. Boyd, 1994)

тодорхой зан төлвийг гүйцэтгэсэнээр үр дүнд хүрнэ гэсэн *итгэл үнэмшил*, *хүлээлт* зэрэг нь хүмүүст тухайн зан төлвийг хэрэгжүүлэх эерэг хандлагыг бий болгодог, (Shapiro, 1982), (Owen-Smith, 2001), (Gulbrandsen, 2005), (M. Goethner, 2012) нарын эрдэмтэд *энтрепренершип үйл ажиллагаанд оролцох, судалгааны үр дүнгээ арилжаалах зэрэгт байгууллагын зүгээс таатай дэмжлэг, урамшуулал* байвал эрдэмтдийн шинэ бизнес эхлүүлэх хандлага илүү тааламжтай болох ба тодорхой цаг хугацаа, хүчин чармайлтаа академик энтрепренершипт зориулна, (Huughe, 2015) *байгууллагын уур амьсгал* нь хувь хүний энтрепренершип үйл ажиллагаанд хандах хандлага, үйлдэлд нөлөөлнө, (Virginia Fernandez-Rivez, 2014) *зах зээл, технологи, хэрэглэгчийн хэрэгцээний талаарх мэдлэг* нь энтрепренершипт чиглэсэн эерэг хандлагыг бий болгоход хүчтэй хувь нэмэр оруулдаг ба эдгээр мэдлэг, үр чадвар, туршлагыг үндсэндээ бизнесийн түншүүдтэй ойр харилцан хамааралтай байснаар олж авдаг гэсэн дүгнэлтүүдийг тус тус танилцуулсан байдаг. Тиймээс бид хувь эрдэмтний патент эзэмшсэн байдал, нийгмийн сүлжээ, холбоо болон хүлээж буй үр өгөөж зэрэг нь тэдний энтрепренершипт хандах хандлагад эерэгээр нөлөөлж шинэ бизнес эрхлэх зорилго, хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлнэ гэж үзэж **Н1а, Н2а, Н3а** таамаглалуудыг дэвшүүлж дүн шинжилгээ хийлээ.

Төсөөлөгдсөн зан төлвийн хяналтаар (PBC) дамжин энтрепренер зорилгод (EI) нөлөөлөх хүчин зүйлс

Төсөөлөгдсөн зан төлвийн хяналт буюу хувь хүний өөрийн үнэлэмжийг хүчтэй болгон хөгжүүлэх үр өгөөжтэй арга бол аливаа даалгаварыг дахин давтан гүйцэтгэх, сайн туршлага хуримтлуулах явдал байдаг (Wood. R., 1989). Өөрөөр тайлбарлавал өмнөх ажлын хүрээнд олж авсан туршлага, үр чадварууд хүний өөрийгөө үнэлэх үнэлэмжтэй эерэг хамааралтай байдаг. Мөн нийгмийн ятгалаг, дэмжлэгээр энтрепренер байх итгэл үнэмшил (entrepreneurial self-efficacy) ихсэх ба хувь хүний энтрепренершип үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгддэг (Nancy G. Boyd, 1994) байна.

Бид судалгаанд оролцогчдын энтрепренершип үйл ажиллагаанд оролцож байсан туршлагаас илүү патент эзэмшсэн байдал, нийгмийн сүлжээ, хүлээгдэж буй үр өгөөж зэрэг хүчин зүйлс хувь эрдэмтний зан төлвийн хяналтад эерэгээр нөлөөлөх замаар энтрепренер болох зорилгыг нэмэгдүүлнэ **Н1б, Н2б, Н3б** гэсэн таамаглалуудыг дэвшүүлэв.

Шууд нөлөөлөл

Эдийн засгийн хүчин зүйлсийн нэг хүлээгдэж буй үр өгөөж буюу ирээдүйд бий болох үр дүн их сургуулийн багш нарын энтрепренер болох зорилгод шууд

нөлөөлөх боломжтой гэж **НЗс** таамаглалыг, мөн төлөвлөгдсөн зан төлвийн онолын дагуу энтрепренер байх зорилгод хувь багшийн хандлага, зан төлвийн хяналт болон нийгмийн хэм хэмжээ шууд нөлөөлнө гэж **Н4** таамаглалуудыг тус тус дэвшүүлэн үр дүнг гаргалаа.

2.2 Судалгааны арга зүй

Судалгаанд МУ-ын 12 их сургуулийн нийт 373 багш оролцсон. Санал асуулгыг Microsoft Form ашиглан боловсруулж их сургуулийн багш нарт e-мэйл хаяг болон фэйсбүүк чатаар илгээсэнээс 371 санал хүчинтэй байсан. Интернэтээр судалгаа авах нь санал асуулгын зарим хэсгийг бөглөхгүй орхих, хүчингүй болох зэрэг эрсдлийг бууруулж байсан боловч цаг хугацаа их шаардсан. Судалгааны таамаглалыг (Ajzen, 1991)-ны төсөөлөгдсөн зан төлвийн онол дээр суурилан гаргасан ба (M. Goethner, 2012)-ын энтрепренер болох зорилгод хүмүүн капитал болон хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжийн нөлөөллийг авч үзсэн судалгааны загварыг ашигласан. Санал асуулгыг (M. Goethner, 2012), (Francisco Licbn), (Saeid Karimi H. J., 2017), (Virginia Fernandez-Pirez, 2014) (Stephen J. Franklin, 2001) нарын судалгааны асуулгыг ашиглан боловсруулсан. Энтрепренершипийн салбарын нэр томъёог гадаад хэлнээс монгол руу орчуулахад зарим нэг хүндрэлүүд гарч байсан ба асуулгын утга агуулгыг бүрэн гаргах шаардлагын улмаас ихэнх асуултууд урт, нуруу болсон байх магадлалтай. Дэвшүүлсэн таамаглалуудаа шалгахын тулд судалгааны SPSS23, SmartPLS программ ашиглан статистик дүн шинжилгээ хийв.

1.3 Судалгааны асуулга, хэмжүүр, боловсруулалт

2.3.1 Сэтгэлзүйн болон эдийн засгийн хүчин зүйлсийг илэрхийлэх хувьсагчид, хэмжих үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөөлөх чадвар, найдвартай байдлын шинжилгээ

Их сургуулийн багш нарын шинэ бизнес эхлүүлэх зорилгыг хэмжих асуулга маань 5-н бүлэг асуултаас бүрдэнэ. Эдгээр асуулгуудыг боловсруулахдаа (Virginia Fernandez-Pirez, 2014), (Saeid Karimi H. J., 2017), (Francisco Licbn), (Virginia Fernandez-Pirez, 2014), (Martin Obschonka, 2012), (M. Goethner, 2012) нарын судалгааны асуулгыг ашигласан бөгөөд тус бүрийг Лайкертын 5-н шкалаар үнэлүүлсэн (1=санал огт нийлэхгүй байна, 5= бүрэн санал нийлж байна).

Энтрепренер болох зорилгыг тодорхойлох хүмүүн капиталын туршлага, үр чадварыг үнэлэхийн тулд профессор, багш нарын патент эзэмшиж буй байдлыг асуулгаар тодруулсан. Нийт оролдогчдоос “сүүлийн таван жилд

оюуны өмчөө хамгаалж патент авсан уу” гэсэн асуултад 0=патент мэдүүлсэн, 1=үгүй гэсэн хариултаас сонгох боломжийг олгосон. Нийгмийн капиталыг хэмжихдээ гарааны бизнес эрхлэхэд ач холбогдолтой байдаг нийгмийн сүлжээ, харилцаа, холбоог илэрхийлэх (M. Goethner, 2012) судалгааны 2 асуулгыг ашиглаж Лайкертын 5-н шкалаар үнэлүүлсэн. Эрдэмтэн M. Goethner (2012) их сургуулийн профессорууд судалгааны ажлаа арилжаалах үйл ажиллагаанд оролцоходоо хүлээгдэж буй үр ашгийг хэрхэн харж, юунд илүү төвлөрч буйг илрүүлэхийн тулд “шинжлэх ухааны нэр хүндийн өсөлт”, “хувийн орлогын өсөлт” гэсэн хоёр хувьсагчийг авч үзсэн байдаг. Бидний судалгаанд дээрх хоёр үзүүлэлт дээр нэмж 3-н хувилбарыг нэмсэн. Үүнд: “багшлах ур чадвар дээшлэх”, “судалгааны чанар өсөх”, “их сургуулийн нэр хүнд өсөх” гэсэн 5-н үзүүлэлт багтсан. (хариултын сонголт 1=санал огт нийлэхгүй байна, 5= бүрэн санал нийлж байна).

Дээрх бүлэг асуулгуудын хувьсагчуудаа төлөөлөх чадвар болон найдвартай байдал зэргийг шалгаж үзэхэд КМО шалгуурын үр дүн 0.918, бодит гүйцэтгэл 64.941% гарсан нь түүврийн тоо хангалттай хүрэлцээтэй байгааг, Бартлеттийн тестийн утга (sig=.000) статистик ач холбогдолтой гарсан нь хүчин зүйлийн шинжилгээ үр дүнтэй болохыг илэрхийлж байна. Асуултуудын найдвартай байдлыг илэрхийлэх Кронбах альфа коэффициент 1-д их ойрхон, буюу 0.7-с их гарсан (0.75-0.83) судалгааны асуулга оновчтой гэж дүгнэн, дараах 24 асуулгуудаар санал асуулга авч боловсруулалт хийх нь үндэслэлтэй бөгөөд найдвартай гэж үзлээ.

Хүснэгт 1. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн болон найдвартай байдлын шинжилгээ

		1	2	3	4	5	
Хүлээгдэж буй үр оооож (Expected outcomes)	Судалгааны чанар дээшилнэ	.827					
	Их сургуулийн нэр хүнд өснө	.777					
	Академик нэр хүнд өснө	.746					
	Багшлах ур чадвар дээшилнэ	.740					
	Хувийн орлого өснө	.660					
Энтрепренер болох зорилго (Entrepreneurial intention)	Гарааны компани байгуулах арга замуудыг судлаж байна		.791				
	Би ойрын ирээдүйд гарааны бизнес эхлүүлбэ гэж бодож байна		.741				
	Гарааны компани байгуулах талаар нухацтай бодож үзсэн		.740				
	Миний дараагийн карьерын зорилго компани байгуулах		.739				

Энтрeнepнepиш хандах хандлага (Attitude to entrepreneurship)	Би гарааны бизнес эхлүүлвэл сэтгэл ханамжтай байх болно			.739		
	Би гарааны бизнес эхлүүлэхдээ дуртай байх болно			.697		
	Багш нар гарааны компани байгуулах нь сайн зүйл			.689		
	Бизнес эрхлэгчид сонирхолтой санагддаг			.618		
	ИС багш гарааны бизнес эрхэлж чадахуйц байх ёстой			.613		
Төсөөлөгдсөн зан толийн хяналт (Perceived behavioral control)	Би шинэ бизнес санааг хэрхэн хөгжүүлэхийг сайн мэддэг			.803		
	Компани байгуулахад шаардлагатай мэдлэг, чадвар надад бий			.799		
	Компани удирдах надад хялбар байх болно			.609		
	Хэрэв би бизнес эрхлэвэл амжилт гаргаж чадна			.516		
Нийгмийн капитал (Social capital)	ИС-ийн дэмжлэг, зөвлөгөө үнэ цэнэтэй байдаг			.821		
	Манай сургууль шинэ бизнес эхлүүлэхэд өдөөдөг			.820		
	Манай хамт олон намайг компани байгуулахыг дэмжинэ			.709		
	Би надад тус болох мэргэжилтнүүдийг сайн танина			.550		
	Надад бизнесийн хүрээнд олон найз нөхөд бий			.553		
				Бодит гүйцэтгэлийн хувь 64.941 КМО = .918 Bartlett's test $\chi^2=4172.990$ (df=253, sig=.000)		

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Хянагч хүчин зүйлс

Судалгааны загвар ёсоор энтрeнepнep болох зорилгод их сургуулийн багш нарын хандлага, нийгмийн хэм хэмжээ, төсөөлөгдсөн зан төлөв хэрхэн нөлөөлж байгаа тодруулахын тулд хамаарлын шинжилгээ хийсэн. Ингэхдээ оролцогчдын нас, хүйс, албан тушаалын зэрэглэл, эзэмшсэн мэргэжил, судалгааны ажлын төрөл зэргийг хянагч хувьсагчаар авч үзсэн болно.

3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд оролцогчид ба ерөнхий мэдээлэл

Судалгаанд оролцогчдын 26.5% нь профессор, 65.7% нь багш, 7.8% нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Эзэмшсэн мэргэжлийн тухайд 25.1% бизнесийн удирдлага, 21.9% боловсрол, 18.4% инженер болон үйлдвэрлэлийн салбарын мэргэжилтнүүд оролцсон. Насны бүлгээр авч үзвэл 30-39 насныхан 31.6%, 40-49 нас 40.6%, 50-иас дээш насныхан 21.2% байна. Хүйсийн хувьд эрэгтэй 27.8%, эмэгтэй 72.2% байлаа. Дээд боловсролын салбарт ажилласан жил, туршлагыг авч үзвэл 11-20 жил ажилласан багш нар 43.5%, 20-с дээш жил ажилласан 28.4%, 1-10 жил ажилласан 27.0% гэсэн ерөнхий статистик гарсан.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн ерөнхий мэдээлэл

Хүйс	Тоо	Хувь	Эзэмшсэн мэргэжил	Тоо	Хувь
Эрэгтэй	104	27.8%	Боловсрол	70	18.9%
Эмэгтэй	270	72.2%	Урлаг, хүмүүнлэг	14	3.8%
			Нийгмийн шинжлэх ухаан	38	10.2%
Нас	Тоо	Хувь	Бизнес ба удирдахуй	86	23.2%
20-29	18	4.8%	Биологи, байгалийн шинжлэх ухаан	19	5.1%
30-39	118	31.6%		13	3.5%
40-49	152	40.6%	Математик, статистик	11	3.0%
50-59	79	21.2%	Мэдээлэл, харилцаа холбоо	72	21.3%
60-с дээш	7	1.8%	Инженерчлэл ба үйлдвэрлэл	36	9.9%
Ажиллаж буй жил	Тоо	Хувь	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	9	2.4%
1-5 жил	47	12.6%	Аялал жуучлал	3	0.8%
6-10 жил	58	15.5%	Хөдөө аж ахуй		
11-15 жил	100	26.7%	Ажиллаж буй их сургууль	Тоо	Хувь
16-20 жил	63	16.8%	АШУҮИС	41	11.1%
20-с дээш	106	28.4%	МУБИС	23	6.2%
Албан тушаалын зэрэглэл	Тоо	Хувь	МУИС	57	15.2%
Профессор, дэд профессор	99	26.5	ХААИС	37	9.9%
Ахлах багш, багш	246	65.7	ХҮИС	30	8.0%
Эрдэм шинжилгээний ажилтан	29	7.8	ШУТИС	91	24.3%
			СЭЗИС	11	2.9%
			ХУИС	21	5.6%
			Бусад ИС	63	16.8%

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Судлаачдын таамаглаж байснаар нас, хүйс, эзэмшсэн мэргэжил, ажилласан жил зэрэг хүчин зүйлс нь эрдэмтдийг энтрепренершип үйл ажиллагаанд

оролцоход нөлөөлнө гэсэн үр дүн гарсангүй. Зарим судалгааны үр дүн профессоруудын энтрепренершип үйл ажиллагаатай холбогдох нь хамт олны бусад гишүүдээс хоёр дахин илүү байдгийг нотлон харуулсан (Bart Claryssea, 2011) бол бидний судалгаагаар их сургуулийн багш нарын албан тушаалын зэрэглэл ахих (багшаас профессорын албан тушаал хүртэл) тусам энтрепренер үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэх магадлал тун бага ($\beta = 0.11, \rho < 0.01$) байгаа үр дүн гарсан. Мөн судалгааны ажлын төрөл эрдэмтдийн судалгаагаар арилжаалах үйл ажиллагаанд оролцоход нөлөөлөх магадлал (Lam, 2010) өндөр байдаг тул бид оролцогчдоос ямар төрлийн судалгаанд илүү их цаг, хүчин чармайлт зарцуулдаг болохыг асуухад; суурь судалгаа 40.5, захиалгат судалгаа 23.6, хэрэглээний судалгаа 10.2, бусад төрлийн судалгаа 25.7 хувь эзэлж байна. Судалгааны ажлын төрөл энтрепренершип үйл ажиллагаатай хамааралтай байна гэж таамаглаж байсан үр дүн гарсангүй. Энэ нь энтрепренершип үйл ажиллагаанд оролцох нь манай багш нарын хийж байгаа судалгааны ажлын төрлөөс үл хамаарч буйг харууллаа.

Судалгааны эхний асуулгаар МУ-ын их сургуулиудын багш нар их сургууль сургалт, судалгаа, энтрепренершиппийг хөгжүүлэх гэсэн гурван чиг үүргээс алийг чухалчилж байгааг онцолж харахыг хүссэн. Үүнд: 1/ сургалт, судалгааны чиг үүргүүдийн алийг илүүд үзэж байна гэсэн асуултад ижил тэнцүү байх шаардлагатай гэж 39.1%, судалгаа илүү байх хэрэгтэй 51.9%, 2/ сургалтыг илүүд үзэх үү, энтрепренершип чиг үүргийг илүүд үзэх вэ гэсэн асуултад; 23,3% нь хоёул адил түвшинд байх хэрэгтэй гэж үзсэн бол 60,6% нь энтрепренершиппийг илүүд үзсэн байна. Харин 3/ судалгаа, энтрепренершип хоёрын алийг чухалд авч үзэж байгааг асуухад; энэ хоёр чиг үүрэг хоёулаа ижил байх шаардлагатай болохыг 31,4%, энтрепренершип илүү байх хэрэгтэй гэж 52,6% нь хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 3. Их сургуулийн үндсэн цэргүүдийн чухал байдлыг харьцуулах судалгааны үр дүн

Их сургуулийн үндсэн чиг үүргүүд	n	Min	Max	Mean	Std.D	Тайлбар
Сургалт - Судалгаа үнэлгээ 1-2-3-4-5-6-7-8-9	371	1.0	9.0	5.7	1.73	51,9% судалгааг сургалтаас илүүд үзсэн
Сургалт - Энтрепренершип үнэлгээ 1-2-3-4-5-6-7-8-9	371	1.0	9.0	6.0	1.78	60,6% энтрепренершиппийг сургалтаас илүүд үзсэн

Судалгаа - Энтрепренершип үнэлгээ1-2-3-4-5-6-7-8-9	371	1.0	9.0	5.8	1.83	52,6% нь энтрепренершипыг судалгаанаас илүүд үзсэн
--	-----	-----	-----	-----	------	---

Эх сурвалж: Судалгааны үр дүн

3.1 Сэтгэлзүйн хүчин зүйлсийг тодорхойлох судалгааны үр дүн

(M. Goethner, 2012)-ын судалгаагаар энтрепренерт хандах хандлага болон төсөөлөгдсөн зан төлвийн хяналт нь энтрепренер болох зорилгыг таамаглагч хүчин зүйл байж чадна, харин нийгмийн хэм хэмжээ үүнтэй хамаарал бага бөгөөд статистик ач холбогдолгүй гэсэн үр дүн гарсан байдаг. Бидний судалгаагаар дээрх 3-н хүчин зүйлүүд хамааран хувьсагчаа /EI/ урьдчилан тайлбарлах чадвартай байсан боловч нийгмийн хэм хэмжээ нь харьцангуй сул ач холбогдолтой байлаа. МУ-ын их сургуулиудын багш нарын оролцсон судалгааны үр дүнгээс харахад тэдний энтрепренер болох зорилгын дундаж утга 2.97-3.54 байгаа бол энтрепренершипт хандах хандлага 3.41-3.82 гэсэн харьцангуй өндөр утга гарсан. Эндээс их сургуулийн багш нарын энтрепренершипт хандах хандлага өндөр байна тиймээс дараагийн түвшний арга хэмжээг зөв зохион байгуулах, улмаар багш нарын гарааны бизнес эрхлэх, энтрепренершип үйл ажиллагаанд оролцох оролцоог дээшлүүлэх боломж байна гэсэн дүгнэлтэд хүрч болох юм. Харин багш нарын бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартаа итгэх итгэл буюу төсөөлөгдсөн зан төлвийн хяналт 3.06-3.45, нийгмийн хэм хэмжээ 2.66-3.0 гэсэн утгууд гарч байна. Энэ нь их сургуулиудын зүгээс энтрепренершип үйл ажиллагааг дэмжих бодлого, зохицуулалтууд сул байгааг илэрхийлэх бөгөөд цаашлаад хувь багшийн энтрепренер байх чадвар, зан төлөвтөө итгэх итгэлийг бууруулахад нөлөөлж болохыг үгүйсгэхгүй. Хүснэгт 4-д бүх хувьсагчдын үнэлгээний ерөнхий түвшинг нэгтгэн харуулав.

Хүснэгт 4. Энтрепренер зорилгыг тодорхойлох хувьсагчдын ерөнхий үнэлгээний түвшин нэгдсэн байдлаар

Асуулгын утга	Дундаж утга	Стандарт хазайлт	Бүлгийн дундаж утга
Энтрепренер болох зорилго			
Би гарааны компани байгуулахад бэлэн байна	3.54	.906	3.20
Би арааны компани байгуулах талаар нухацтай бодож үзсэн	3.20	.966	
Гарааны компани байгуулах арга замуудыг судлаж байна	2.97	1.06	
Миний карьерын дараагийн зорилго компани байгуулах	3.16	.990	
Би ойрын ирээдүйд гарааны бизнес эхлүүлье гэж бодож байна	3.15	1.05	

Энтрепренершипт хандах хандлага			
ИС-ийн багш гарааны бизнес эрхэлж чадахуйц байх ёстой	3.61	.837	3.65
Багш нар гарааны компани байгуулах нь сайн зүйл	3.41	.852	
Би гарааны бизнес эхлүүлвэл сэтгэл ханамжтай байх болно	3.81	.813	
Би гарааны бизнес эхлүүлэхдээ дургтай байх болно	3.83	.795	
Бизнес эрхлэгчид сонирхолтой санагддаг	3.61	.858	
Төсөөлөгдсөн зан төлвийн хяналт			
Компани байгуулж удирдах надад хялбар байх болно	3.10	.851	3.22
Компани байгуулахад шаардлагатай мэдлэг, ур чадварууд надад бий	3.28	.897	
Би шинэ бизнес санааг хэрхэн хөгжүүлэхийг сайн мэддэг	3.06	.908	
Хэрэв би бизнес эрхлэвэл амжилт гаргаж чадна	3.45	.824	
Нийгмийн хэм хэмжээ			
Манай хамт олон намайг компани байгуулахыг дэмжинэ	3.00	.898	2.78
ИС-ийн зүгээс гарааны бизнест зориулсан дэмжлэг, зөвлөх үйлчилгээ надад үнэ цэнэтэй байдаг	2.67	1.00	
Манай сургуулийн уур амьсгал намайг шинэ бизнес эхлүүлэхэд өдөөдөг	2.66	.928	

Эх сурвалж: Судалгааны үр дүн

3.2 Эдийн засгийн хүчин зүйлсийг тодорхойлох судалгааны үр дүн

Өмнөх хоёр бүлэгт энтрепренершипт нөлөөлөх эдийн засгийн үзүүлэлтүүдийн талаар дэлгэрэнгүй тайлбар хийсэн. Хүмүүн капиталыг профессор, багш нарын патент эзэмшиж буй байдлаар хэмжсэн бол нийгмийн капиталыг 2 үзүүлэлтээр, хүлээгдэж буй үр өгөөжийг 5-н үзүүлэлтээр хэмжсэн. (Хүснэгт 1- т хүчин зүйлүүдийн төлөөлөх чадвар, найдвартай байдлын шинжилгээг харуулсан). Үр дүнгээс харахад судалгаанд оролцсон их сургуулийн багш нарын 17.2% нь патент эзэмшиж байгаа бол 82.8% ямар нэгэн патент эзэмшдэггүй гэж хариулсан. Их сургууль тус бүрээр патент эзэмшсэн байдлыг задлан шинжлэхэд ШУТИС, ХААИС, АШУҮИС, МУИС зэрэг инженер, нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэж буй их сургуулиудын патентын туршлага бизнесийн удирдлагаар мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудынхаас илүү байв.

Нийгмийн капитал буюу нийгмийн сүлжээ, харилцаа холбоог тодорхойлох бүлэг асуулгын дундаж утга 2.8 байсан. Хэдийгээр энэ бүлгийн дундаж утга бага байгаа ч нийгмийн капиталын үзүүлэлтүүд хандлага ($\beta = 0.324$, $t = 3.536$, $p < 0.05$), зан төлвийн хяналт ($\beta = 0.568$, $t = 10.834$, $p < 0.05$) -ыг нэмэгдүүлэх замаар энтрепренер болох зорилгод нөлөөлж байгаа үр дүн гарсан. Харин хүлээгдэж буй үр өгөөжийг тодруулах бүлэг асуулгын дундаж утга 3.7 гарсан. Эндээс багш нар, энтрепренер болсноор ирэх үр өгөөжийг хүлээн зөвшөөрч байна гэсэн дүгнэлт хийх боломжтой. Хүснэгт 5-т харуулснаар багш нар энтрепренер болсноор хувийн орлого өснө, судалгааны чанар дээшилнэ, их

сургуулийн нэр хүнд өснө гэж үзсэн байна.

Хүснэгт 5. Эдийн засгийн хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	Асуулгын утга	Дундаж утга	Стандарт Хазайлт	Бүлгийн дундаж утга
Нийгмийн капитал (Social capital)	Надад бизнесийн хүрээнд олон найз нөхөд бий	3.04	.852	2.8
	Бизнес эрхлэхэд туслах мэргэжилтнүүдийг би сайн танина	2.64	.945	
Хүлээгдэж буй үр өгөөж (Expected outcomes)	Академик нэр хүнд өснө	3.39	.915	3.7
	Хувийн орлого өснө	3.85	.747	
	Багшлах ур чадвар дээшилнэ	3.60	.909	
	Судалгааны чанар дээшилнэ	3.93	.782	
	Их сургуулийн нэр хүнд өснө	3.89	.823	

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Хүснэгт 6. Бизнес эрхлэх магадлал

Магадлал	Давтамж	Хувь
0 хувь	49	13.2
20 хүртэл хувь	96	25.9
21-40 хувь	85	22.9
41-60 хувь	66	17.8
61-80 хувь	34	9.2
81-ээс дээш хувь	26	7.0
100 хувь	15	4.0
Нийт оролцогчдын тоо	371	100.0

Тэгвэл их сургуулийн профессор, багш нарын ойрын ирээдүйд бизнес эрхлэх төлөвлөгөө байгаа эсэхийг тодруулахад 0 хувийн магадлалтай 13,2%, 40 хүртэл хувийн магадлалтай 48.8%, 41-60 хүртэл хувийн магадлалтай 17.8% байгаа бол 61-с дээж хувийн магадлалтай 20.2% байна. Бизнес эрхлэх магадлал өндөр байх тусам энтрепренер болох зорилго нэмэгдэх магадлал өндөр байх тул регрессийн шинжилгээ хийж үзэхэд статистикийн хувьд ач холбогдолтой байсан ($\beta = 0.546$, $t=12.503$, $p<0.01$). Бизнес эрхлэх магадлал өндөр байх нь нас, хүйс, мэргэжил, албан тушаалыг зэрэглэл, туршлага зэргээс

хамааралтай эсэхэд шинжилгээ хийхэд наснаас бусад хүчин зүйлс хамааралгүй гэсэн үр дүн гарсан. Оролцогчдын нас, бизнес эрхлэх магадлалтай бага зэрэг хамааралтай буюу эрэгтэй багш нарын бизнес эрхлэх магадлал эмэгтэй багш нарынхаас өндөр байлаа.

1.3 Хувьсагчуудын хоорондын хамаарал, шууд болон шууд бус нөлөөллийн шинжилгээний үр дүн

Дэвшүүлсэн загвар, таамаглалын дагуу төлөвлөгдсөн зан төлвийн онолын хувьсагчидтай эдийн засгийн хүчин зүйлсүүд шууд болон шууд бусаар нөлөөлж буй эсэхийг SmartPLS 3.0 ашиглан path analysis хийж үр дүнг гаргалаа.

Шууд нөлөөлөл -ийн хувьд патент эзэмших байдал нь багш нарын энтрепренерт хандах хандлага ($\beta=-0.023$ $\rho=.005$) болон төсөөлөгдсөн зан төлвийн хяналттай ($\beta=-.151$ $\rho=.005$) сөрөг хамааралтай байсан. Харин нийгмийн капитал(SC) буюу нийгмийн сүлжээ, холбоо энтрепренершипт хандах хандлага ($\beta= .324$, $\rho < .005$), төсөөлөгдсөн зан төлвийн хяналт ($\beta= .568$, $\rho < .005$)- тай тус тус эерэг хамааралтай бөгөөд статистик ач холбогдолтой гарсан. Их сургуулийн багш нарын энтрепренершипт үйл ажиллагаанаас хүлээж буй үр өгөөж тэдний энтрепренершипт хандах хандлага ($\beta= .618$, $\rho < .005$), төсөөлөгдсөн зан төлвийн хяналт ($\beta= .459$, $\rho < .005$), энтрепренер болох зорилго ($\beta= .378$, $\rho < .05$)-той тус тус эерэг хамааралтай байна. Хүснэгт 7-д шууд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлыг дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт 7. Хүчин зүйлсийн хоорондын шууд хамаарал

Path	Standardize Beta	Standard error	T statistics	P value	Remarks
Pat ATE	-.023	0.039	0.677	.499	Rejected
Pat PBC	-.151	0.038	3.123	.002	Supported
SC ATE	0.324	0.042	3.536	.000	Supported
SC PBC	0.568	0.041	10.834	.000	Supported
ExB ATE	0.618	0.040	14.363	.000	Supported
ExB PBC	0.459	0.047	7.068	.000	Supported
ExB EI	0.378	0.053	0.394	.694	Rejected
ATE EI	0.321	0.054	5.959	.000	Supported
SN EI	0.204	0.053	3.829	.000	Supported
PBC EI	0.282	0.055	5.173	.000	Supported

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Шууд бус нөлөөлөл: Бидний авч үзсэн судалгааны загвараар эдийн засгийн хүчин зүйлүүдийн энтрепренер байх зорилгод нөлөөлөхөд төлөвлөгдсөн зан төлвийн онолын хувьсагчид /ATE, SN, PBC/ дундын хүчин зүйл болж байгаа. Таамаглал 1-д их сургуулийн багш нарын патент эзэмшсэн байдал тэдний энтрепренершипт хандах хандлага болон төсөөлөгдсөн зан төлвийн хяналтаар дамжин энтрепренер зорилгод нөлөөлнө гэж үзсэн. Энд патент эзэмшилт багшийн энтрепренершип хандах хандлагыг дээшлүүлж улмаар энтрепренер зорилгод нөлөөлнө гэсэн **H1a** таамаглалын нөлөөлийн хүч бага ($\beta = -.151$), урвуу хамааралтай, статистик ач холбогдолгүй ($t = .660$, $p > .005$) гарч таамаглал батлагдсангүй. Мөн патент эзэмшсэн байдал нь багшийн төсөөлөгдсөн зан төлвийн хяналтыг дээшлүүлэх замаар энтрепренер болох зорилгод нөлөөлнө гэсэн **H1b** таамаглалын нөлөөлийн хүч сул, урвуу ($\beta = -.033$) байсан боловч статистикийн хувьд ач холбогдолтой ($t = 2.589$, $p < .005$) байснаар таамаглал хэсэгчлэн батлагдсан болно. Таамаглал 2-т нийгмийн капиталын хүчин зүйлс багшийн хандлага болон төсөөлөгдсөн зан төлвийн хяналтад нөлөөлөх замаар энтрепренер болох зорилгыг нэмэгдүүлнэ гэж тооцсон. Багш нарын нийгмийн сүлжээ, холбоо сайн байх нь тэдний энтрепренершипт хандах хандлагыг нэмэгдүүлж цаашлаад энтрепренер болох зорилгыг өдөөнө гэсэн **H2a** таамаглалын хувьд нөлөөлийн хүч ($\beta = .048$), статистикийн ач холбогдол ($t = 2.995$, $p < .005$) гарсан бол нийгмийн сүлжээ, холбоо сайн байх нь багш нарын төсөөлөгдсөн зан төлвийн хяналтыг дээшлүүлэх замаар энтрепренер болох зорилгод нөлөөлнө гэсэн **H2b** таамаглалын нөлөөлийн хүч ($\beta = .124$), статистик ач холбогдолтой ($t = 4.702$, $p < .005$) гэсэн үр дүн гарснаар таамаглалууд бүрэн батлагдсан.

Таамаглал 3-т багшийн хүлээж буй үр өгөөж ба энтрепренер болох зорилго хоёрын дундын хүчин зүйл нь хандлага болон төсөөлөгдсөн зан төлвийн хяналт байна гэж авч үзсэн. Юуны түрүүнд багш нар энтрепренершип үйл ажиллагаанаас хүлээж буй үр өгөөж тэдний энтрепренершипт хандах хандлагыг өсгөснөөр энтрепренер болох зорилгыг нэмэгдүүлнэ гэсэн **H3a** таамаглалын хувьд нөлөөлийн хүч ($\beta = .184$), статистикийн ач холбогдолтой ($t = 5.264$, $p < .005$) байна. Дэвшүүлсэн үр өгөөжүүд дотроос хандлагад хамгийн их нөлөөлж байгаа нь хувийн орлого өсөлт ($\beta = .272$), их сургуулийн нэр хүнд өсөлт ($\beta = .160$) зэрэг үзүүлэлтүүд байсан. Мөн багшийн төсөөлж буй үр дүн тэдний зан төлвийн хяналтад эерэгээр нөлөөлснөөр энтрепренер болох зорилго ихэснэ гэсэн **H3b** таамаглалын үр дүн ($\beta = .093$), статистикийн ач холбогдол ($t = 2.589$, $p < .05$) гарсан, энд хүчин зүйлс хоорондоо эерэг хамааралтай, статистикийн ач холбогдолтой хэдий ч харьцангуй сул хамааралтай нь харагдсан. Төсөөлөгдсөн зан төлвийн хяналтад хамгийн их нөлөөлж байгаа үзүүлэлтүүд нь хувийн

орлогын өсөлт ($\beta = .194$), багшийн ур чадварын өсөлт ($\beta = .212$) зэрэг байна.

Энтрепренершипт хандах хандлага, төсөөлөгдсөн зан төлвийн хяналт, нийгмийн хэм хэмжээ болон хүлээгдэж буй үр өгөөж зэрэг хүчин зүйлс энтрепренер болох зорилгод шууд нөлөөлнө гэсэн **H3c, H4** таамаглалууд бүрэн батлагдсан. Хүснэгт 8-д шууд бус хамаарлын шинжилгээ, нөлөөллийн хүч, статистик ач холбогдол зэргийг харуулав.

Хүснэгт 8. Шууд бус хамаарлын шинжилгээ

Hypothesis	Path	Standardize Beta	Standard error	T statistics	P value	Remarks
H1a	P_{at} ATE EI	-.009	0.013	0.660	.510	Rejected
H1b	P_{at} PBC EI	-.033	0.013	2.589	.010	Supported
H2a	SC ATE EI	.048	0.016	2.995	.003	Supported
H2b	SC PBC EI	.124	0.026	4.702	.000	Supported
H3a	ExB ATE EI	.184	0.035	5.264	.000	Supported
H3b	ExB PBC EI	.093	0.022	2.589	.000	Supported

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Энтрепренершип үйл ажиллагаанд тулгарах саад бэрхшээлүүд энтрепренер болох зорилгод нөлөөлөх үү?

Орчны нөхцөл байдал хувь хүний шинэ бизнес эхлүүлэх зорилгыг өдөөж бас саад болж байдаг (Nabi & Linan, 2013). Үүнтэй адил энтрепренершип үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл нь хувь хүний шинэ бизнес эхлүүлэх чадварыг хязгаарлаж, өөрийн чадвартаа итгэх итгэлийг бууруулдаг байна. Судлаач (Saeid Karimi H. J., 2017) нар өөрсдийн судалгаандаа хувь эрдэмтний төсөөлж буй саад бэрхшээл нь түүний энтрепренерт хандах хандлага болон төсөөлөгдсөн зан төлвийн хяналттай урвуу хамааралтай бөгөөд энтрепренер болох зорилгод шууд бусаар нөлөөлнө гэдгийг онцолсон байдаг. Харин төсөөлж буй дэмжлэг тусалцаа, зан төлвийн хяналттай эерэг хамааралтай ба хангалттай нөөцтэй, зорилгыг биелүүлэхэд тулгарах саад бэрхшээл бага гэдгийг мэдэх тусам хувь хүний зан төлвийн хяналт илүү сайн байдаг (Ajzen, 1991). Өөрөөр хэлбэл орчны дэмжлэг, тусалцаа сайн байх тусам энтрепренер болох чадвартаа итгэх итгэл илүү өндөр болдог байна.

Их сургуулиудад судалгааг арилжаалахад тулгарч буй бэрхшээлүүд

Багш нарын энтрепренер болох сэдэлд нөлөөлөх хүчин зүйлсийг судлахаас гадна тэднийг энтрепренершип үйл ажиллагаанд оролцох, патент авах зэрэгт тулгарч буй саад бэрхшээлийг тодруулах зорилгоор асуумждаа 11 бэрхшээлийг тодорхойлж “тийм”, “үгүй” гэсэн хариултыг авсан. Эдгээр бэрхшээлүүдийн

багш нарын энтрепренершигт хандах хандлага, төсөөлөгдсөн зан төлвийн хяналтад хэрхэн нөлөөлж буйд хамаарлын шинжилгээ хийж үзэхэд зөвхөн “лаборатори тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу” гэсэн үзүүлэлт энтрепренер болох зорилгод хамааралтай, статистик ач холбогдолтой ($\beta=0.14$, $\rho<0.05$) гарсан. Үлдсэн 10 бэрхшээлийн хувьд энтрепренер байх зорилготой ямар нэгэн хамаарал, ач холбогдолгүй байлаа. Тиймээс судалгаанд оролцогчдын хариулснаар бэрхшээлүүдийг хамгийн их давтамжтайгаас бага руу эрэмбэлэн хүснэгт 9-т харууллаа.

Харин багш нар яагаад академик энтрепренершиг үйл ажиллагаанд оролцохгүй байгаа шалтгааныг тодруулах 8-н үзүүлэлтүүдээс (0=үгүй, 1=тийм) сонголт хийх боломжийг судалгаанд оролцогчдод олгосон. Хариултаас харахад багшийн ачаалал их, энтрепренер болох ямар нэгэн оролдлого хийгээгүй, манай сургууль дээр гарааны бизнес эрхлэх сайн туршлага байхгүй гэсэн шалтгаанууд хамгийн их давтамжтай байлаа. Эдгээр үзүүлэлтүүд бүгд энтрепренер болох зорилготой урвуу хамааралтай байсан бөгөөд хамгийн хүчтэй хамааралтай үзүүлэлт нь “миний үндсэн үүрэгт ажил биш” ($\beta=-0.169$, $t=-3.197$, $\rho<0.05$) гэсэн шалтгаан байлаа.

Хүснэгт 9. Патент авахад тулгарч буй саад бэрхшээл болон энтрепренершиг үйл ажиллагаанд оролцохгүй байх шалтгааныг эрэмбэлэн харуулав.

Патент авах, энтрепренер үйл ажиллагаанд оролцоход тулгарч буй бэрхшээл	Эрэмбэ	Энтрепренершиг үйл ажиллагаанд оролцохгүй байх шалтгаан	Эрэмбэ
Урамшуулалын систем сул	1	Багшийн ачаалал их	1
Санхүүжилтийн эх үүсвэр хомс	2	Ямар нэгэн оролдлого хийгээгүй	2
Лаборатори, тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу	3	Манай сургууль дээр гарааны бизнес эрхлэсэн сайн туршлага байхгүй	3
Оюуны өмчийн бодлого зохицуулалт сул	4	Гарааны бизнес эрхлэх мэдлэг, чадвар хомс	4
Удирдлагын шийдвэр гаргалтын процесс удаан	5	Манай сургууль дээр гарааны бизнес эрхлэх боломж байхгүй	5
Удирдлагын багийн дэмжлэг сул	6	Шинэ технологи бүхий бүтээгдэхүүн гарах боломжгүй	6
Хамтран тууштай ажиллах баг байгаагүй	7	Миний ажил үүргийн хүрээнд хийх шаардлага байхгүй	7

Технологи дамжуулах болон дундын оффисын үйл ажиллагаа сул	8	Ажлын үндсэн үүрэг биш	8
Гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоо сул	9		
Хамт олны эсэргүүцэл их	10		

4. Хэлэлцүүлэг

Их сургуулийн профессор, багш нар шинжлэх ухааны мэдлэг, судалгааны үр дүнд бий болсон шинэ технологи, бүтээгдэхүүнээ зах зээлд хүргэх зорилгоор гарааны компани байгуулснаар энтрепренер болдог. Академик энтрепренершипийн хүрээнд шинжлэх ухааны ололт амжилтанд суурилсан спинн-офф, гарааны компаниудыг олноор төрүүлэн гаргах, байгууллагын гишүүдийг /багш, оюутан, ажилчид/ энтрепренер байхад дэмжих бүхий л механизм, зохицуулалтуудыг хийх шаардлагатай байдаг. Үүнд: стратегийн зорилгоо сайн тодорхойлох, шийдвэр гаргалтанд байгууллагын бүх түвшний оролцоог хангах, судалгаа, хөгжил, инновацийг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх, сайн урамшуулалын систем нэвтрүүлэх, энтрепренер соёлыг байгууллагын бүхий л түвшинд төлөвшүүлэх (M. Guetero, 2010) гэх мэт өөрчлөлт, шинэчлэлийг хийх хэрэгтэй. Хувь хүний үйл хөдлөлийг чиглүүлэх гадаад орчны эдгээр зохицуулалтуудаас гадна тодорхой зан төлвийг хэрэгжүүлэх дотоод сэдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах шаардлагатай байдаг. Бид МУ-ын их сургуулиудын багш нарын энтрепренер болох сэдэл, зорилгыг тодорхойлох судалгааг хийсэн нь онол, практикийн чухал ач холбогдолтой байсан бөгөөд дараа дараагийн судалгааны ажлууд хийх суурь болж өгсөн.

Энэхүү судалгаа маань хоёр үндсэн хэсэгтэй эхний хэсэгт энтрепренер болох зорилгод нөлөөлөх сэтгэлзүйн хүчин зүйлсийн судалгаа, хоёр дахь хэсэгт эдийн засгийн хүчин зүйлсийн судалгаа багтана. Сэтгэлзүйн судалгааны үр дүн бидэнд энтрепренершипт хандах хандлага, төсөөлөгдсөн зан төлвийн хяналт, нийгмийн хэм хэмжээ (нөлөөлөх хүч харьцангуй бага) зэрэг хүчин зүйлс багшийн энтрепренер болох зорилгод нөлөөлж байгааг харсан. Статистик шинжилгээгээр их сургуулийн профессор, багш нарын энтрепренершипт хандах хандлагын дундаж утга 3.6, төсөөлөгдсөн зан төлвийн дундаж утга 3.2 байгаа бол нийгмийн хэм хэмжээг илэрхийлэх утга 2.7 байна. Эндээс багш нарын энтрепренершипт хандах хандлага харьцангуй сайн байгаа ч энтрепренер болох үр чадвартаа итгэх итгэл бага, мөн энтрепренершипийг дэмжих орчны зохицуулалтууд сул байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Цаашлаад энтрепренер байх зорилгод нөлөөлөх хүч их байгаа хандлага,

зан төлвийн хяналт зэргийг өдөөх эдийн засгийн хүчин зүйлсүүд, тэдгээрийн нөлөөллийг харьцуулж үзсэн. Ингэхдээ хүмүүн капитал (патент эзэмшсэн байдал) болон нийгмийн капитал (нийгмийн харилцаа холбоо, түншлэл)-ын үзүүлэлтүүдийг сонгон судалгаагаа үргэлжлүүлсэн. Хүчин зүйлсүүдийн хоорондын хамаарлын шинжилгээгээр патент эзэмших байдал хандлага болон төсөөлөгдсөн зан төлвийн хяналттай урвуу хамааралтай гарсан нь ижил төстэй судалгааны ажлуудаас тэс өөр үр дүн байсан. Энэ нь судалгаанд оролцсон багш нар патент эзэмшээгүй ч тэдний энтрепренершипт хандах хандлага сайн, мөн патент эзэмшээгүй ч энтрепренер болох чадвартаа итгэж байна гэсэн утгыг илэрхийлж байна. Харин нийгмийн капиталын үзүүлэлтүүд хандлага болон төсөөлөгдсөн зан төлвийн хяналттай эерэг хамааралтай байсан. Эндээс нийгмийн харилцаа холбоо сайн байх нь хувь эрдэмтний бизнест хандах хандлага, өөрийн чадварт итгэх итгэлийг нэмэгдүүлдэг гэсэн дүгнэлтэд хүрч болно. Эдийн засгийн үр ашгийн тухайд хувийн орлого өсөх, академик нэр хүнд өсөх (M. Goethner, 2012) гэсэн хоёр үндсэн үзүүлэлт дээр хувь багшийн өөрийн багшлах болон судалгаа хийх ур чадвар өсөх, их сургуулийн нэр хүнд өсөх гэсэн үзүүлэлтийг нэмж судалгаа авсан. Хамгийн чухал зүйл бол хувийн орлогын өсөлт, судалгааны чанарын өсөлт, их сургуулийн нэр хүндийн өсөлт зэрэг үр дүн багшийн энтрепренершипт хандах хандлагад харьцангуй хүчтэй нөлөөлнө гэсэн үр дүн байна.

Бидний судалгааны ололттой тал нь МУ-ын их сургуулийн багш нарын энтрепренер сэтгэлгээг судласан анхны судалгаа байсан бол сул тал нь зарим нэг хувьсагчийг илэрхийлэх үзүүлэлтүүдийг сонгохдоо алдаа гарсан нь судалгааны эцсийн үр дүнд нөлөөлсөн байж болзошгүй. Тухайлбал хүмүүн капиталыг зөвхөн патент эзэмшсэн байдлаар хэмжсэн. Гэтэл нийт судалгаанд оролцогчдын дөнгөж 17.2% патент эзэмшсэн байсан. Тиймээс цаашид илүү нарийн үзүүлэлтүүдээр эрдэмтэдийн бизнес эрхлэх сэдлийг тайлбарлах судалгаануудыг хийх хэрэгцээ шаардлага байна.

Патент эзэмшсэн багш нараас патент авахад тулгарч байсан саад бэрхшээлүүдийг тодруулахад урамшууллын бодлого сул, лаборатори тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу, удирдлагын шийдвэр гаргалтын процесс удаан, оюуны өмчийн бодлого зохицуулалт сул гэсэн үзүүлэлтүүд хамгийн их санал авсан байсан. Хэдийгээр патент эзэмшээгүй ч энтрепренер үйл ажиллагаанд оролцоход саад болж хүчин зүйл байгаа шалтгаануудыг тодруулахад багшийн ажлын ачаалал их, багшийн үндсэн ажил үүрэг биш гэж үзсэн байна.

Бидний дараагийн судалгаа маань их сургуулиудын алсын хараа, стратеги төлөвлөгөө, их сургуулиудын энтрепренершип үйл ажиллагааг дэмжих дэд бүтцийн хөгжил зэрэг үзүүлэлтүүд дээр төвлөрөх болно. Энэ судалгааны үр

дүнд дээр дурьдсан байгууллагын дотоод хүчин зүйлс гишүүдийн энтрепренер сэдэл, зан төлөвт нөлөөлж байгаа эсэхийг тодруулах бөгөөд тодорхой хэмжээний зөвлөмж гарах боломжтой гэж үзэж байна. Судалгааг баримт бичгийн судалгаа болон бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар авах, боловсруулалтын илүү нарийн аргачлалыг ашиглахаар төлөвлөж байна.

5. Дүгнэлт

Манай улсын хувьд төр, засгийн зүгээс инноваци, энтрепренершипийн хөгжүүлэхэд анхаарал хандуулж байгаа хэдий ч их сургуулиудын манлайлал, оролцоо хангалтгүй, институциудын хамтын ажиллагаа, экосистемийн хөгжил сул байгаа. Тиймээс энэ салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах судалгааны ажлуудын хэрэгцээ шаардлага байна.

Академик энтрепренершипийн хөгжүүлэхэд их сургуулиудын профессор багш нарын оролцоо, тэдний энтрепренер болох сэдлийг тодорхойлох энэхүү судалгаа нь МУ-ын 8-н их сургуулийн 371 профессор, багш нарыг хамарсан анхны судалгаа болсон. Судалгаа нь багш нарын энтрепренер болох зорилгод тэдний хандлага, зан төлвийн хяналт, нийгмийн хэм хэмжээ болон эдийн засгийн хүчин зүйлс нөлөөллийг тооцсоноор онолын ач холбогдолтой. Цаашид их сургуулиудын оюутнуудын энтрепренер сэдлийг тодорхойлох судалгааг авахаас гадна багш, оюутнуудын энтрепренер болох зорилгод нөлөөлж буй байгууллагын дотоод хүчин зүйлсийг судлах, тэдгээрийн хамаарлын хүчийг тодорхой судалгааны аргачлал ашиглан гаргаж ирэх боломжийг олж харснаар энэхүү судалгааны практик ач холбогдол улам нэмэгдэх боломжтой.

Судалгааны үр дүнг нэгтгэж үзвэл:

- 1) Их сургуулийн багш нар энтрепренершипийг хөгжүүлэх зүйтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Учир нь судалгаанд оролцогчдын 60.6% нь их сургууль сургалтаас илүү энтрепренершипийг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй гэж үзсэн бол 52.6% нь судалгаанаас илүү энтрепренершипийг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.
- 2) Багш нарын энтрепренер болох хандлагыг тодорхойлох бүлэг асуулгын дундаж утга 3.6 байсан. суулгууд дотроос “би гарааны компани эхлүүлбэл сэтгэл ханамжтай байх болно-3.81” “би гарааны компани байгуулахдаа дуртай байх болно-3.83” гэсэн утгуудтай гарсан нь бусад үзүүлэлтүүдээс харьцангуй өндөр үр дүн байсан. Бидний судалгаагаар хандлага нь энтрепренер зорилгод эерэгээр ($\beta=0.321$, $t=5.959$, $p<0.01$) нөлөөлж байсан энэ нь хандлагыг нэмэгдүүлэх замаар энтрепренершипийг хөгжүүлэх боломжтойг харуулсан үзүүлэлт юм.

Нөгөө талаас МУ-ийн их сургуулийн багш нар энтрепренер байхыг хүсэх үү?, тэдэнд хичээл заах, судалгаа хийх чиг үүргээс өөрийг зүйлийг хийх шаардлага, сонирхол байхгүй гэсэн урьдчилсан таамаглал үгүйсгэгдэж байгаа юм.

- 3) Төсөөлөгдсөн зан төлвийн хяналт буюу багш нарын энтрепренер байх мэдлэг ур чадвартаа итгэх итгэл 3.2 гэсэн дундаж үзүүлэлттэй байгаа ч, багш нар “хэрэв энтрепренер болбол амжилт гаргаж чадна-3.45” гэж хариулсан нь цаашид академик энтрепренершипийг хэрэгжүүлэхэд байгууллагын гишүүдийн энтрепренершип боловсрол, туршлагыг хөгжүүлэх хэрэгцээ байгааг харуулж байна. Түүнчлэн төсөөлөгдсөн зан төлвийн хяналтыг нэмэгдүүлснээр энтрепренер болох сэдлийг нэмэгдүүлнэ ($\beta=0.282$, $t=5.173$, $p<0.01$) гэдэг нь бидний судалгаагаар батлагдсан.
- 4) Нийгмийн хэм хэмжээ энтрепренер болох зорилгод нөлөөлдөгийг олон судалгааны ажлууд батласан байдаг. Бидний судалгаагаар энэ үзүүлэлтийн дундаж утга 2.78 буюу хангалтгүй дүнтэй гарсан бөгөөд нөлөөллийн утга ($\beta=0.204$, $t=3.829$, $p<0.01$) маш бага байгаа. Эндээс бид энтрепренерүүдийг төрүүлэх, энтрепренершипийг хөгжүүлэхэд их сургууль, хамт олны зүгээс үзүүлж буй дэмжлэг сул байна гэсэн дүгнэлт хийсэн.
- 5) Ойрын ирээдүйд бизнес эрхлэх төлөвлөгөөтэй эсэхэд шинжилгээ хийхэд нийт багш нарын 20.2% нь, тэдний бизнес эхлүүлэх магадлал 61 хувиас дээш гэж хариулжээ. Мөн бизнес эрхлэх төлөвлөгөөтэй байх нь энтрепренер болох зорилготой эерэг хамааралтай байсан ($\beta=0.546$, $t=12.503$, $p<0.01$). Тэгэхээр их сургуулиудад потенциал бүхий энтрепренерүүд байна гэж үзэж болно.
- 6) Харин бид хэрэглээний судалгаа хийж байгаа багш, профессоруудын энтрепренер байх магадлал өндөр гэж таамаглаж байсан боловч энд ямар нэг ач холбогдол байсангүй.
- 7) Шууд нөлөөллийн шинжилгээний үр дүнгээс харахад патент эзэмших байдал багш нарын энтрепренершипт хандах хандлагад шууд нөлөөлөхгүй байгаа боловч тэдний зан төлвийн хяналттай сөрөг болон сул хамааралтай байсан. Тэгэхээр багш нар патент эзэмшдэггүй ч энтрепренер болж чадна гэдэгтэй итгэдэг байх магадлалтай.
- 8) Нийгмийн сүлжээ, танил тал зэрэг нь багш нарын хандлага ($\beta=0.048$, $t=2.995$, $p<0.05$), зан төлвийн хяналт ($\beta=0.124$, $t=4.702$, $p<0.05$)-д нөлөөлж байгаа нь нийгмийн дэмжлэг, тусалцаа чухал

болохыг харуулж байна. Эндээс их сургууль, аж үйлдвэр, засгийн газрын хамтын ажиллагааг хөгжүүлж багш нарын нийгмийн сүлжээ, харилцааг холбоог өргөжүүлэх нь тодорхой ач холбогдолтой болохыг харж болох юм.

- 9) Мөн энтрепренершип үйл ажиллагаанд оролцсоны дараа бий болох үр дүн багш нарын хандлага ($\beta = 0.618$, $t = 14.363$, $p < 0.05$), зан төлвийн хяналтад ($\beta = 0.459$, $t = 7.068$, $p < 0.05$) шууд болон хүчтэй нөлөөлж байгаа үр дүн гарсан. Эндээс энтрепренершипыг хөгжүүлснээр гарах үр дүнг ойлгуулан таниулах, бий болох үр өгөөжийг хүртэх системийг зөв бүрдүүлж өгснөөр багш нарын энтрепренер зорилго, үйл ажиллагааг нэмэгдүүлэх бас нэгэн боломж харагдаж байна.
- 10) Байгууллагын гишүүд илүү их шагнал, урамшуулал бүхий ажилд анхаарал хандуулж өөрсдийн зан төлвөө тэдгээр ажлуудыг хийхэд чиглүүлдэг (Kerr 1975), тиймээс их сургуульд энтрепренершип уур амьсгалыг идэвхжүүлэхийн тулд энтрепренер үйл ажиллагааг дэмжих урамшуулалын тогтолцоог бий болгох хэрэгтэй (Friedman and Silberman 2003; Shane 2004; Siegel et al. 2003) гэдгийг эрдэмтэд судалгааны ажлаараа онцолсон байдаг. Бидний судалгааны үр дүнгээр дээрх эрдэмтдийн дүгнэлт нотлогдсон ба багш нар энтрепренершип үйл ажиллагаанд оролцоход саад болдог зүйлсд 1) урамшуулалын систем сул, 2) санхүүжилтийн эх үүсвэр хомс, 3) лаборатори, тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу, 4) оюуны өмчийн бодлого зохицуулалт сул, 5) удирдлагын шийдвэр гаргалтын процесс удаан гэсэн үзүүлэлтүүд хамгийн их давтамжтай байлаа. Харин энтрепренершип үйл ажиллагаанд оролцохгүй байх шалтгааныг тодруулахад 1) багшийн ачаалал их, 2) ямар нэгэн оролдлого хийгээгүй, 3) манай сургууль дээр гарааны бизнес эрхлэсэн сайн туршлага байхгүй, 4) гарааны бизнес эрхлэх мэдлэг, чадвар хомс гэсэн үзүүлэлтүүд өндөр давтамжтай байна. Эдгээр үр дүнгээс харахад багш нарыг энтрепренер үйл ажиллагаанд татан оролцуулахдаа их сургуулийн зүгээс урамшуулалын зөв системийг бүрдүүлэх, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, лаборатори, тоног төхөөрөмжийн хүрэлцээ, хангамжийг сайжруулах, тэдгээрийг зөв зохистой удирдлагаар хангах нь зүйтэй байна.
- 11) Бидний судалгаагаар их сургуулийн багш нарын энтрепренер үйл ажиллагаанд оролцох зорилгод сэтгэлзүйн болон эдийн засгийн зарим хүчин зүйлс нөлөөлдөг болох нь батлагдсан ба цаашид байгууллагын орчны хүчин зүйлсийн нөлөөллийг судлах, эсвэл энтрепренер зорилго нь тэдний зан төлвийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж байгааг нарийвчлан судлах зайлшгүй шаардлага байна.

Ашигласан материал:

- [1] Ajzen, I. (1991). The theory of planned behavior. *Organizational behavior and Human Decision Processes*, 50(2), 179-211.
